

Хичээл: Даатгалын андеррайтингийн үйл явц

CII Cert Level Unit: Insurance Underwriting Practice (IF3)



Хэрэгжүүлэгч



Хамтран хэрэгжүүлэгч



Хичээлийн ерөнхий агуулга

Хичээл: 3 өдрийн хичээлээс бүрдэнэ.

Эхний өдөр	Даатгалын бизнес дэх андеррайтингийн үүрэг оролцоо болоод андеррайтинг хийх ерөнхий процедур, үйл явцын талаар байх юм.
Хоёр дахь өдөр	Даатгалын гэрээ ба түүнийг дагалдах бичиг баримт документуудын стандарт практик болон даатгалын андеррайтингийн бодлого практикын тухай байх болно.
Сүүлийн өдөр	Даатгалын хураамж тооцох суурь техник практик ба туслах үйлчилгээнүүд, давхар даатгал, эрсдэлийн хуримтлалыг удирдах тухай байна.
Мэдлэг шалгах тест	Хичээл эхлэхийн өмнөх тест болон хичээл дууссаны дараах тестийн шалтгалттай байна.



Агуулга

1. Даатгалын бизнес дэх андеррайтингийн үүрэг оролцоо

- Эрсдэлийг судалж, зөвшөөрөгдсөн, нийцэх эрсдэлийг сонгож даатгах нь
- Гол, чухал мэдээлэл. (Material Information) Түүнийг мэдээлэх үүрэг, хариуцлага хууль зүйн үндэслэл /provisions and remedies in Consumer Insurance Law 2012, Insurance Act 2015/ Монголын нөхцөл байдалтай харьцуулж сайжруулах зүйлсүүдийн талаар дурдах
- Гол, чухал мэдээллийг цуглуулах , олж авах аргачлал, стандарт практикууд

2. Андеррайтингийн процедур

- Quote буюу үнийн санал боловсруулах, танилцуулах
- Даатгалын хураамжийг тогтоох хувилбарууд
- Гэрээ байгуулах үйл явц, гэрээ байгуулагдсаныг тодорхойлох
- Даатгалын гэрээ, даатгалын полиси, ковернот, сертификат ба тэдгээрийн зориулалт ба ялгаа
- Гэрээ тодорхой байх дүрэм (contract certainty rule)
- Хураамж төлөлт, хураамжийг удирдах, цуглуулах үйл явц



Агуулга

3. Даатгалын гэрээ, бичиг баримтын стандарт, практик

- Бүтэц, харагдах байдал, хэлбэр
- Скедул / Schedule
- Хасагдах Хэсэг / Exclusions
- Зохицуулалт нөхцөлүүд / General Conditions
- Warranty, Precedent Condition, Representations / Монголын даатгалын нөхцөл байдалд хэрхэн яаж ойлгож болох вэ?

4. Даатгалын андеррайтингийн бодлого ба практик

- Эрсдэлийг ангилах ба төрөлжүүлэх (risk classification and categorization)
- Андеррайтингийн Шалгуур үүсгэх
- Хөрөнгө ба Бизнес Тасалдлын Даатгалын андеррайтинг
- Хариуцлагын Даатгалын андеррайтинг
- Автомашины Даатгалын андеррайтинг



Агуулга

5. Хураамжийн үнийг тооцоолох суурь практик, техникүүд

6. Туслах үйлчилгээнүүд

- Утсаар тусламж, зөвлөгөө өгөх функц
- Албан ёсны, зөвшөөрөгдөх засвар, сэлбэг, эд анги нийлүүлэгч
- Эрсдэлийн контрол (risk control), бууруулах удирдах зөвлөмж үйлчилгээ

7. Андеррайтер өөрийнхөө эрсдэлийг даатгуулах нь буюу давхар даатгал – эрсдэлийн хуримтлалыг удирдах (risk accumulation management)



Нэр томъёоны тайлбарууд

1. Onus of proof – Нотлох үүрэг
2. Express condition – Гэрээнд тусгайлан заасан нөхцөлүүд
3. Implied condition – Гэрээнд тусгайлан заагаагүй боловч мөрдөх ёстой ерөнхий нөхцөлүүд
4. Misrepresentation – Даатгуулах эрсдлийн талаар буруу ташаа, худал мэдээлэл өгөх
5. Material facts – Тухайн эрсдэлийг даатгах үгүй эсэхэд нөлөөлөх материаллаг мэдээлэл, фактууд
6. Utmost good faith – Чин шударгын зарчим
7. Duty of disclosure – Эрсдэлийн талаарх мэдэж буй бүх мэдээллийг хуваалцах үүрэг
8. Duty of fair presentation – Эрсдэлийн талаарх мэдээллийг чин шударгаар, үнэн зөвөөр танилцуулах үүрэг



Нэр томъёоны тайлбарууд

9. Loss quantum – Хохирлын хэмжээ
10. Condition precedent – Угтвар нөхцөл
11. Warranty – Амлалт
12. Severity – Хохирлын үр дагаврын цар хүрээ
13. Salvage – Хохиролд өртсөн зүйлээс үлдэх өртөг тооцох
14. IBNR – (Incurred but not reported) – Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан
15. Deductible – Хариуцах хэсэг
16. Excess – Хариуцах хэсгийн өөр нэг нэршил (иргэдийн даатгалд илүү ашигладаг)
17. Franchise – Хариуцах хэсгийн өөр нэг нэршил (гэнэтийн осол, sickness гэрээнүүдэд ашигладаг)



Оршил

Даатгал бол хамтын дундын сангийн концепци дээр тулгуурладаг бизнес. Олон тооны даатгуулагчид хураамж хэлбэрээр дундын санд мөнгө төвлөрүүлж тэрхүү сангаар хохиролд өртсөн цөөн тооны даатгуулагчдын хохирлыг нөхөн барагдуулж байдаг. Энэхүү процесст андеррайтерийн гүйцэтгэх үүрэг бол тэрхүү дундын санг хамгийн үр ашигтай, тогтвортой бөгөөд боломжит түвшинд ашигтай байх нөхцөлөөр удирдах явдал байдаг. Энэ агуулгаар андеррайтер хүний үүрэгт:

- Хүмүүсийн дундын санд оруулах эрсдэлийг үнэнлэх / assess the risk which people bring to the pool;
- Тухайн эрсдэлийг дундын санд авах үгүй эсэх, авах бол хэр хэмжээгээр авахыг шийдэх /decide whether or not to accept the risk, or how much to accept;
- Эрсдэлийг хүлээн авах нөхцөл санал, хамгаалалтын хүрээ зэргийг тодорхойлох / determine the terms, conditions and scope of cover to be offered; and
- Тухайн эрсдэлд тохирох хамгийн боломжит шударга сайн үнийг тооцоолох / calculate a suitable, equitable premium.

Энэхүү хичээлээр бид даатгалын андеррайтинг хийх ерөнхий процедур дараалал болоод ердийн даатгалын андеррайтинг хийхэд авч үзэх ёстой тодорхой хүчин зүйлсүүдийн талаар судлах болно.



Бүлэг 1: Даатгалын бизнес дэх андеррайтингийн үүрэг оролцоо

Даатгалын салбарын үүслийн үе буюу далайн даатгалын үед (marine insurance), даатгалд хамруулахыг зорьж буй усан онгоц эсвэл усан онгоцон дээр тээвэрлэх ачааны мэдээллийг slip гэж нэрлэгдэж заншсан цаасан дээр тусгадаг байв.

Брокер слипийг Ллойдсын даатгалын зах руу барьж орно.

Эрсдэлийг үүрэх этгээд слип дээр тусгасан мэдээллүүдийг үзээд, хамгийн доод хэсэгт буюу мэдээллүүдийн доор гарын үсгээ, үүрэхийг хүсэж буй хувь хэмжээгээ бичдэг байв. Энэ хүнийг андеррайтер гэж нэрлэж ирсэн билээ.

Андеррайтинг өнөө үед хамаагүй илүү нарийн, төвөгтэй үйл ажиллагаа болж хөгжсөн хэдий ч гол, суурь концепци, үзэл санаа огт өөрчлөгдөөгүй, хэвээрэй л байна.



Бүлэг 1: Даатгалын бизнес дэх андеррайтингийн үүрэг оролцоо

Даатгалын бизнес дэх андеррайтингийн үүрэг оролцоо

- Эрсдэлийг судалж, зөвшөөрөгдсөн, нийцэх эрсдэлийг сонгож даатгах нь
- Гол, чухал мэдээлэл. (Material Information) Түүнийг мэдээлэх үүрэг, хариуцлага хууль зүйн үндэслэл /provisions and remedies in Consumer Insurance Law 2012, Insurance Act 2015/ Монголын нөхцөл байдалтай харьцуулж сайжруулах зүйлсүүдийн талаар дурдах
- Гол, чухал мэдээллийг цуглуулах , олж авах аргачлал, стандарт практикууд



Good Faith – Чин шударгын зарчим

Даатгалын гэрээний хуулийн суурь зарчим

Бусад төрлийн гэрээ: Caveat Emptor or let the buyer beware (худалдан авагч юмаа шалгаж авна уу. Зарагдсан бараа буцаахгүй зарчим)

Худалдан авагч тал авч буй зүйлсийнхээ талаар илүү сайн судлах үүрэгтэй. Худалдагч тал зарж буй зүйлсийнхээ талаар бүхнийг тоочих албагүй.

Даатгалын гэрээ: Good faith or uberrima fides (худалдан авагч худалдагчид асуусан зүйлсд нь үнэн зөв хариулах зарчим)

Талууд бие биедээ сайн итгэлээр хандах буюу нэг талаас даатгуулагч даатгуулах зүйлийнхээ талаар, нөгөө талаас даатгагч санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ талаар чин шударгаар, илэн далангүй тоочиж танилцуулах үүрэгтэй. **Үүнийг чин шударгын, сайн итгэлээр хандах зарчим гэх бөгөөд даатгалын гэрээ хэлцлийн амин чухал суурь зарчим юм.**



Good Faith – Чин шударгын зарчим

Аливаа гэрээ хуулийн дагуу хүчин төгөлдөр байхад тодорхой элементүүд оршин байх шаардлагатай.

- Санал / an offer
- Саналыг хүлээх авах / acceptance of the offer
- Гэрээг байгуулах болж буй суурь сонирхол, солилцох үнэт зүйлс / consideration

Даатгалын компанид машинаа даатгуулахаар холбогдох мэдээллийг танилцуулж, хураамжийн санал авах хүсэлт ирүүлэх	Эрсдэлийн танилцуулга / The presentation of the risk
Даатгагч хариу санал танилцуулах	Үүнийг санал буюу offer
Даатгуулагч даатгагчийн саналыг хүлээн авах	Саналыг хүлээн авах буюу acceptance
Даатгуулагч даатгагчид хураамж төлөх болон Даатгагч нөхөн төлбөр төлөх тухай амлах	Суурь сонирхол буюу consideration

Good Faith – Сайн итгэлийн зарчим

Даатгалын гэрээний хуулийн суурь зарчим

Даатгалын гэрээ суурилж буй энэхүү зарчим нь даатгал авахыг хүсэж буй талд даатгагчийн асуусан бүх мэдээллийг үнэн зөвөөр гаргаж өгөх үүргийг оногдуулсан байдаг.

- Consumer contract: Иргэдийн даатгалд – Даатгагчийн асуусан асуултад болон сайн дураар нэмэлтээр гаргаж өгч буй бүх мэдээллүүд нь үнэн зөв бөгөөд бүрэн дүүрэн (full and accurate) байх ёстой.
- Non-consumer contracts: Байгууллагын даатгалд – Fair presentation буюу тухайн эрсдэлийн талаар өөрийн мэдэж байгаа, мэдэж байх учиртай бүх мэдээллийг үнэн зөвөөр гаргаж, тодорхой танилцуулах үүрэг хүлээдэг.



Material Information – Материаллаг мэдээлэл

Marine Insurance Act 1906

Every circumstance is material which would influence the judgment of a prudent insurer in fixing the premium or determining whether to take the risk. Ердийн ухаалаг даатгагчийн тухайн эрсдэлийг бичих эсэх болоод тохиромжит хураамж тооцох тухай шийдвэрт нөлөөлж болох бүхий л материаллаг нөхцөл байдал.

- Тухайн эрсдэлийн талаарх онцгой, тусгайлсан факт мэдээллүүд
- Даатгал сонирхох болсон аливаа шалтгаанууд
- Тухайн даатгалын төрөл, хэлбэрт хамаарах тухайлсан мэдээллүүд

Зарим сул талууд:

- Даатгагчид илүү давуу байдал олгосон буюу юуг материаллаг мэдээлэл гэж үзэх эсэхийг даатгагч өөрөө шийддэг
- Мөн гаргаж өгсөн мэдээллүүдийг зөвхөн нөхөн төлбөрийн харилцааны үед л үнэлж дүгнэдэг буюу даатгагч даатгал хийгдэх үед материаллаг мэдээлэлд ач холбогдол өгөх гэхээсээ нөхөн төлбөр үүссэн үед материал мэдээллийн тухай сөхөж нөхөн төлбөрөөс татгалзах, гэрээнээс зугтах нөхцөлүүдийг үүсгэж байв. Энэ муу практикийг **Underwriting at the claims stage** гэж ч нэрлэдэг.



Presenting the risk – Эрсдэлийг танилцуулах нь

Consumer Insurance (Disclosure and Representations) Act 2012

Consumer даатгуулагчид: Duty to take reasonable care not to make a misrepresentation to the insurer

- Зөвхөн даатгагчийн асуусан асуултуудад үнэ зөв бөгөөд бүрэн дүүрэн хариулах үүрэгтэй.
- Хэрэв даатгуулагч өөрийн сайн дураар нэмэлт мэдээлэл гаргаж өгөх бол тэрхүү мэдээлэл үнэн зөв байх үүрэгтэй.

Non-Consumer даатгуулагчид: Duty of fair presentation of the risk

- Даатгуулагч тал (proposer) өөрийн мэдэж буй болон мэдэж байх ёстой бүхий л материал мэдээллийг гаргаж өгөх. Хэрэв ямар нэг мэдээ материал дутуу орхисон, мэдүүлээгүй байвал даатгагчид заавал мэдэгдэж нэмэлт тайлбар мэдээлэл хүргүүлэх үүрэгтэй.
- Даатгуулагч мэдээллийг гаргаж өгөхдөө тодорхой бөгөөд ашиглаж болохуйц (clear and accessible) хэлбэрээр бэлтгэж танилцуулах үүрэгтэй. Гаргаж өгч буй мэдээллүүдээ маш тодорхой хэлбэрээ бэлтгэж хаана ямар мэдээлэл оруулсан талаар тодорхой тэмдэглэлүүд (signposts) оруулсан байх шаардлагатай. Хэрэв мэдээлэл бүрэн дүүрэн биш эсхүл тодорхой биш байвал үүнийг clear and accessible гэж үзэхгүй.



Presenting the risk – Эрсдэлийг танилцуулах нь

Consumer Insurance (Disclosure and Representations) Act 2012

Даатгалын компани талаас мөн дараах үүргүүд хүлээнэ.

- Даатгалын бүтээгдэхүүний төрөл ба тухайн бүтээгдэхүүний зорилтот хэрэглэгч
- Даатгагчаас гаргасан тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх танилцуулга мэдээллийн агуулга
- Асуулгаар асууж буй асуултуудын тодорхой бөгөөд ойлгомжтой байдал
- Тухайн асуултуудад хариулах ач холбогдлын талаар даатгагч хэрхэн ойлгуулж таниулж буй байдал
- Тухайн асуултуудад хариулахгүй байх, буруу хариулт өгөх зэргээс үүсэх үр дагаврын тухай мөн тодорхой танилцуулсан байх
- Агент эсхүл брокер оролцож буй эсэх



Presenting the risk – Эрсдэлийг танилцуулах нь

Duration of the duty of fair presentation

Даатгалын хэлцэл эхлэх үеэс эхлэх ба даатгалын гэрээний хүчинтэй хугацааны туршид энэ үүргийн хугацаа үргэлжилдэг. Даатгуулагч гэрээний дундуур (change a policy mid-term) өөрчлөлт хийхээр бол (даатгалын үнэлгээг эсхүл даатгуулсан хөрөнгийн тодорхойлолт өөрчлөх, эсхүл жолооч нэмэх гэх мэт) энэхүү duty of fair presentation үүрэг нь шинээр гэрээ хийж буйтай адил үзэгдэнэ.

Мөн даатгуулагч policy wording буюу гэрээнд тодорхой нөхцөлүүдэд даатгагчид мэдэгдэл өгөх үүргүүдийг оруулж болдог. Тухайлбал: Хөрөнгийн даатгал: өөр байршилд шилжүүлэх, эсхүл хохирол тохиолдох магадлалыг өсгөсөн аливаа нөхцөл байдлууд, хариуцлагын даатгалд: Бизнес үйл ажиллагааг өргөжүүлсэн тохиолдолд гэх мэт

Pre-cover: fair presentation үүрэг quotation process эхлэх үед эхлэх ба quotation –ны хүчинтэй хугацаа дуусахад дуусгавар болж болно. **Inception, mid term, renewal, claims** гэсэн бүх үе шатуудад энэхүү үүрэг хадгалагдаж хүчин төгөлдөр байдаг.



Non-disclosure and misrepresentation

Non-disclosure: Даатгуулагч өөрийн мэдэж буй зүйлийг даатгагчид мэдэгдээгүй, мэдэж буй зүйл гэдэгт тухайн эрсдэлийг хүлээн авах эсэх болоод ямар нөхцөл, саналаар тухайн гэрээг байгуулах тухай даатгагчийн шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлс.

Misrepresentation: Албан ёсоор өгсөн мэдүүлэг, хариулт буруу, худал байх нөхцөл буюу даатгагчийг тухайн гэрээг байгуулах шийдвэрт ятгасан, хүргэсэн нөхцөл байдал.



Non-disclosure and misrepresentation

Авах арга хэмжээ

Хэрэв санаатайгаар худал хуурмаг мэдээлэл гаргаж өгсөн бол	Хайхрамжгүйгээр буруу мэдээлэл өгсөн бол
Даатгагч гэрээнээс татгалзах эрхтэй.	<p>Хэрэв хэрэглэгч зөв мэдээлэл ирүүлсэн бол даатгагч ямар шийдвэр гаргах байсан бэ гэдгээс хамаардаг.</p> <ul style="list-style-type: none">✓ Хэрэв даатгагч гэрээ хийхгүй байсан бол гэрээг цуцалж болох бөгөөд хураамжийг буцаах ёстой.✓ Хэрэв даатгуулагч гэрээг өөр нөхцөлөөр байгуулах байсан бол даатгагч тухайн гэрээг тухайн нөхцөлүүд үйлчлэх байдлаар авч үзэж болно.✓ Хэрэв даатгуулагч илүү өндөр хураамжтайгаар гэрээг байгуулах байсан бол нөхөн төлбөрийг хувь тэнцүүлэн бууруулж болно.



Physical and moral hazards – Физикал болон зан төлвийн хүчин зүйлс

Hazard and Perils

- A peril can be defined as that which gives rise to a loss.
- A hazard can be defined as that which influences the operation of the peril.

Physical hazard: тухайн эрсдэлийн физикал материаллаг онцлог шинж чанар болон хэмжигдэж болохуйц хүчин зүйлс.

- Motor insurance: жолоочийн нас, машины нөхцөл байдал
- Дэлгүүрийн хамгаалалтын систем: Хамгаалалтын систем сайн байх тусам физикал хазард багатай
- Personal accident and sickness: Даатгуулагчийн мэргэжил
- Хөрөнгийн угсралт хийцлэлийн стандарт: Стандарт өндөр байх тусам физикал хазард бага байна.



Physical and moral hazards – Физикал болон зан төлвийн хүчин зүйлс

Hazard and Perils

- A peril can be defined as that which gives rise to a loss.
- A hazard can be defined as that which influences the operation of the peril.

Physical hazard: Inception hazard, propagation hazard, damageability, exposure hazard and protection

- Motor insurance: жолоочийн нас, машины нөхцөл байдал
- Дэлгүүрийн хамгаалалтын систем: Хамгаалалтын систем сайн байх тусам физикал хазард багатай
- Personal accident and sickness: Даатгуулагчийн мэргэжил
- Хөрөнгийн угсралт хийцлэлийн стандарт: Стандарт өндөр байх тусам физикал хазард бага байна.



Physical and moral hazards – Физикал болон зан төлвийн хүчин зүйлс

Hazard and Perils

- A peril can be defined as that which gives rise to a loss.
- A hazard can be defined as that which influences the operation of the peril.

Moral hazard: Даатгуулагчийн хандлага болоод зан төлөвөөс үүсэх хүчин зүйлс.

- Carelessness: Тухайлбал, жолоочийн хайхармжгүй байдал нь аюул осол тохиолдох магадлал болоод түүний дагуулах хор хохирлын хэмжээг өсгөж болно.
- Dishonesty: Өмнө нь нөхөн төлбөрийн залилан үйлдэж байсан хүнийг урьд өмнө нь нөхөн төлбөрийн залилан гаргаж байгаагүй хүнээс илүү өндөр морал хазардтай гэж үзнэ.
- Social attitudes: Даатгалын компанийг хууран мэхлэх зэргийг хууль бус, ёсзүйгүй үйлдэл гэж бодохгүй байх

Зарим тохиолдолд, физикал болон морал хазардыг ялгаж танихад төвөгтэй байдаг. Учир нь нэг нь нөгөөгөө илтгэх шинж тэмдэг болох тохиолдлууд түгээмэл байдаг. Тухайлбал, үйлдвэрийн маш муу менежмент. Энэ нь зан төлөв, хандлагын аюул занал хэдий ч нөгөө талаас физикал хазард мэтээр оршиж болдог. Жишээ нь: харуул хамгаалалт муутай байх, тодорхой стандартууд хэрэгжүүлдэггүй байх гэх мэт

Obtaining material information – Материал мэдээлэл цуглуулах

Асуулгын хуудас (a proposal form or questionnaire) бол эрсдэлийн тухай андеррайтингийн мэдээлэл цуглуулах хамгийн түгээмэл аргачлал юм. Үүнээс гадна мэдээлэл цуглуулах зарим хэлбэрүүд байдаг. Жишээ нь:

- **Brokers**

Commercial даатгалд брокерын оролцоо маш өндөр байдаг бөгөөд брокерууд андеррайтерт тухайн эрсдэлийг үнэлэхэд шаардагдах бүхий л мэдээлэл, документуудыг бэлтгэж өгдөг. Тухайлбал, risk registers буюу эрсдэл бүрийн бүртгэл лист, нөхөн төлбөрийн түүх, биечилсэн үзлэг шалгалтын тайлан (site inspection report) болон ХАБЭА тайлан гэх мэт

- **Risk surveys**

Ихэвчлэн томоохон хэмжээний, төвөгшил өндөртэй (large and complex) эрсдэлийн үед risk survey ашигладаг. Risk surveyor –уудын гүйцэтгэх үүрэг бол андеррайтерын нүд чих болох явдал бөгөөд андеррайтерт дараах мэдээллүүдийг багтаасан тайлан гаргаж өгдөг. Үүнд:

- Тухайн эрсдэлийн бүтэн танилцуулга / a full description of the risk
- Эрсдэлийн түвшний талаарх үнэлгээ / an assessment of the level of risk
- Тухайн эрсдэлийн хувьд учирч болох хохирлын дээд хэмжээ / a measure of the estimated maximum loss (EML),
- Мөн тухайн эрсдэлийн хүрээнд сайжруулах, засах зүйлсийн жагсаалт / a list of risk improvements



Obtaining material information – Материал мэдээлэл цуглуулах

- **Supplementary questionnaires**

Тодорхой онцлог шинж чанар бүхий эрсдэлийн хэлцэл хийх үед ашигладаг. Тухайлбал:

- Маш өндөр дүнтэй гүйлгээ бүхий мөнгөний эрсдэл / Money risk
- Эртний хуучин барилгын галын эрсдэл
- Үсчиний салоны хариуцлагын эрсдэл: Үсний будаг, өнгөлөгчийн хэрэглээ ашиглалтын тухай нэмэлт мэдээлэл цуглуулах гэх мэт
- **Meeting with clients**
- **Call center**
- **Internet (Compare the market –аас жишээ харуулах)**



Бүлэг 2: Андеррайтингийн процедур

2. Андеррайтингийн процедур

- Quote буюу үнийн санал боловсруулах, танилцуулах
- Даатгалын хураамжийг тогтоох хувилбарууд
- Гэрээ байгуулах үйл явц, гэрээ байгуулагдсаныг тодорхойлох
- Даатгалын гэрээ, даатгалын полиси, ковернот, сертификат ба тэдгээрийн зориулалт ба ялгаа
- Гэрээ тодорхой байх дүрэм (contract certainty rule)
- Хураамж төлөлт, хураамжийг удирдах, цуглуулах үйл явц



Quotations – Үнийн санал танилцуулах

Андеррайтер өөрт хэрэгтэй мэдээллүүдийг цуглуулж васаны дараа тэдгээр мэдээлэлд үндэслэн тухайн эрсдэлийг үнэлэх /assess the risk/, улмаар түүнийг даатгах үгүй эсэх, даатгах бол ямар нөхцөл болзолтойгоор даатгах тухай шийдвэрээ гаргах хэрэгтэй болно.

Ийнхүү андеррайтер тухайн эрсдэлийг даатгах нөхцөл саналаа даатгагчид танилцуулсаныг quotation гэж нэрлэнэ.

Quotation буюу үнэ санал хүргүүлэхдээ Даатгагч гэрээний тодорхой хязгаарлалт, нөхөн төлбө олгохгүй байх нөхцөлүүд болоод бусад даатгагчдаас ялгаатай байх нөхцөлүүдийг Даатгагчид танилцуулсан байх үүрэгтэй.

Quotation –ны хамт хүргүүлж буй нөхцөл, болзолуудыг (terms and conditions) subjectivity гэж нэрлэнэ. An example could relate to property insurance where cover may be provided 'subject to' a survey being carried out on the risk in question. Quotation –ны хамт covering letter, statement of fact гэх мэт документууд дагалдаж болно. Хэрэв даатгуулагч хүсвэл даатгагч гэрээний вординг нөхцөлийг хамт хүргүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, даатгуулагчийг шийдвэр гаргахад шаардлагатай бүх мэдээллээр хангах зорилготой байдаг.

Энэ үеийн даатгагчийн гол үүрэг бөгөөд уламжилж тогтсон сайн практик бол Даатгагчийн танилцуулж буй нөхцөл, болзол санал (terms and conditions) болоод quotation боловсруулахдаа суурилсан мэдээлэл нь даатгуулагч харилцагчид маш тодорхой ойлгомжтой байх ёстой.



Quotations – Үнийн санал танилцуулах

Ноён Браун орон сууц эзэмшигчийн даатгал (household or homeowners insurance) авах хэрэгтэй байгаа ба General Insurance Co руу үнийн санал (quotation) утас цохив. Андеррайтер түүнээс цөөнгүй хэдэн асуулт асуув. Эдгээр асуултууд нь түүнийг Ноён Брауныг даатгах үгүй эсэх, даатгавал ямар нөхцөл, болзол дээр даатгахыг шийдэхэд нь туслах юм.

Андеррайтер ямар асуултууд асуусан байж болох вэ? 5 хариулт бодно уу?



Quotation Procedure – Үнийн санал танилцуулах үйл явц

Quotation – танилцуулах үйл явц

- Үнийн санал нь тодорхой хугацаатай байдаг. Тухайлбал, 14-30 өдөр байж болдог.
- Quotation танилцуулах үед даатгалын хамгаалалт эхлээгүй буюу даатгагч эрсдэлийг үүрээгүй байна. (cover is not effective and the insurer is not on risk). Даатгалын гэрээ хүчин төгөлдөр болохын тулд даатгагч санал буюу (quotation) –оо танилцуулж даатгуулагч саналыг хүлээн авсан байх учиртай. (offer and acceptance)
- Даатгагч ирүүлсэн саналаа буцаагаагүй тохиолдолд, хэрэв даатгуулагч ирүүлсэн санал буюу quotation –г хүчинтэй хугацаанд нь хүлээн авсан тохиолдолд Даатгагч ирүүлсэн саналынхаа дагуу даатгалын гэрээг байгуулах үүрэг хүлээнэ. Даатгалын хамгаалалт (cover is effective) хүчин төгөлдөр болно гэсэн үг.
- Гэхдээ Даатгагчийн үнийн санал гаргаж өгөхдөө суурилсан нөхцөл байдал өөрчлөгдсөн бол Даатгагч гэрээ байгуулах үүрэг хүлээхгүй байж болно.
- Үнийн саналыг хүчинтэй хугацаанд Даатгуулагч саналыг хүлээн авах эсхүл татгалзах эрхтэй.
- Саналын хугацаа дуусаж, даатгуулагч саналыг хүлээн авсан эсэхээ мэдэгдээгүй тохиолдолд санал хүчин төгөлдөр бус болох буюу даатгагч гэрээ байгуулах үүрэг хүлээхгүй. Гэхдээ нөхцөл байдал (circumstances) өөрчлөгдөөгүй бол Даатгагч өгсөн саналын хугацааг сунгаж болно.
- Хэрэв саналд хүчинтэй байх тодорхой хугацаа заагаагүй байвал санал боломжит хугацааны (for reasonable time) турш нээлттэй байна. Ийм нөхцөлд Даатгагч өгсөн саналаа Даатгуулагч түүнийг хүлээн авахаас өмнөх аль ч үед буцаан татах эрхтэй байна.



Quotation - Жишээ

We would need 0...% net basis, max leading share 10%-15% depends on final approval.

1. SUMS INSURED: ...split:

Section 1 – ...

Section 2 – ... Indemnity Period: 12 months

2. Deductible: USD ..., BI ... days.

3. Machinery and computer breakdown extension (physical damage, sub-limit: USD 1,000,000 per occurrence and in aggregate)

4. No CBI is covered under this policy.

5. Strike, Riot, Civil Commotion Clause (Limit: USD 500,000 – any one occurrence, USD2,000,000 in aggregate)

6. Swiss Re Exclusions: (Unless already equivalently excluded in the Original Policy Wording)

ITC Sanctions clause LMA 3100

Terrorism exclusion clause NMA 2921

Nuclear exclusion clause NMA 1975 (a)

Radioactive Contamination Exclusion Clause NMA 1622

Cyber exclusion LMA 5401

War and Civil War Exclusion clause NMA 464

Seepage and pollution exclusion NMA1685

Infectious Disease/Covid-19 Exclusion Clause

Quotation - Жишээ

- Notwithstanding any provision to the contrary, this reinsurance excludes any loss, damage, liability, expense, fines, penalties or any other amount directly or indirectly caused by, in connection with, or in any way involving or arising out of any of the following –including any fear or threat thereof, whether actual or perceived – :
 - Any infectious disease, virus, bacterium or other microorganism (whether asymptomatic or not); or
 - Coronavirus (COVID-19) including any mutation or variation thereof; or
 - Pandemic or epidemic, as declared as such by the World Health Organization or any governmental authority.
 - If the Reinsurer alleges that, by reason of this exclusion, any amount is not covered by this agreement, the burden of proving the contrary shall rest on the Reinsured.
7. Original policy wording (with extension clauses) to be provided and agreed by SR before binding, signed version to be provided to SR within 90 days after inception.
 8. PPW 120 days.
 9. Swiss Re General Conditions for Facultative Business to apply and shall prevail.
 10. Original policy/endorsements, terms, conditions, and claim settlements shall be provided to SR and agreed by SR before commitment.
 11. Claims information as updated in email of ..., and no further loss deterioration as at date of binding or inception whichever is later, otherwise, we will withdraw our indication.
 12. Excluding ex-gratia payment and without prejudice.
 13. Our offer is on the basis that all submission information / slip provided is complete and correct to the best of the Insurer's knowledge. Should there be any material changes to the risk, changes to the claims experience (whether incurred or reported from the date of this offer until the date of binding or otherwise), or corrections to the currently provided information, we must be informed immediately and we reserve the right to change and/or withdraw our offer.
 14. If signing share is to be less than offered, please contact us before binding as this may have an effect on the rate/premium offered.
 15. Final slip to be reviewed and agreed by Swiss Re prior to binding.

Хураамжийн тооцоолол – Premium Calculation

Андеррайтер хүний гол үүргүүдийн нэг нь тухайн эрсдэлд тохирсон зохистой, бодит (Fair and equitable) хураамжийг тооцоолох явдал байдаг. Даатгуулагчаас авах хураамжийн хэмжээ нь түүний даатгуулж буй эрсдэлийн түвшин болон нөхөн төлбөр магадлалыг тусгасан байх учиртай.

- Homogeneous exposure unit – Нэгэн ижил төрлийн эрсдэлийн багц
- The law of large number – Их тооны хууль

Premium rate: Эрсдэлийн түвшин буюу тухайн гэрээгээр нөхөн төлбөр төлөгдөх магадлалыг тусгасан тооцоолол

Premium base: Эрсдэлийн хэмжүүр буюу даатгалын үнэлгээ

Rate per cent and rate per mille

Rate per cent: 100 төгрөг тутамд бодох үнэ. Rate of 1.5 per cent гэвэл 100 төгрөг тутмаас 1.5 төгрөгийн хураамж авна.

Rate per mille: 1000 төгрөг тутамд бодох үнэ. Rate of 2.5 per mille гэвэл 1000 төгрөг тутмаас 2.5 төгрөгийн хураамж авна.

Байшин 250,000 долларын үнэлгээтэй бөгөөд даатгагч 2.5 per mille үнэ өгсөн гэвэл хураамж хэд болох вэ?



Хураамжийн тооцоолол – Premium Calculation

Adjustable premium:

Зарим төрлийн даатгалын бүтээгдэхүүний үнэ тооцоход гэрээ эхлэх үед гэрээний үнэлгээ буюу premium base/exposure тодорхой биш байдаг. Ийм тохиолдолд adjustable premium rate –г гэрээний эхэнд тохиролцож гэрээ дуусгавар болох үед тодорхой болсон гэрээний үнэлгээнээс хураамжийг дахин тооцдог. Урьдчилсан үнэлгээнээс тооцож авсан хураамжийг deposit premium гэдэг.

Flat premium

Хураамжийн хувь тооцохгүйгээр тодорхой мөнгөн дүнгээр хураамжийг шууд тооцдог хэлбэр. Хураамжийн consulting table ашиглах бөгөөд хураамжийн дүн өсөж буурах тодорхой факторуудыг тусгасан байдаг. Автоматжуулсан, компьютерийн программ хэлбэрээр байх нь түгээмэл бөгөөд харгалзах факторуудыг оруулахад хураамж автомат тооцогддог.



Policies, cover notes and certificates of insurance

Даатгалын гэрээ буюу policy: Даатгагч болон даатгуулагчийн хоорондын тохирсон нөхцөл, болзол болоод бусад нөхцөл заалтуудын дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан бичиг баримт. Даатгалын гэрээ буюу policy нь өөрийн техникал бүтэцтэй байх бөгөөд зөвхөн тухайн гэрээг (contract) илэрхийлэх баримт юм. Өөрөөр хэлбэл, даатгалын гэрээ буюу policy хэвлэгдэж гараагүй гэдэг нь даатгалын хэлцэл байгуулаагүй гэсэн агуулга болохгүй. The contract of insurance буюу даатгагч, даатгуулагчийн хооронд хийгдэж буй хэлцэл хуулийн дагуу хүчин төгөлдөр болох нь гэрээ буюу policy –оос тусдаа.

Cover notes: Даатгалын гэрээ буюу policy хэвлэгдэж гарах хүртэл тодорхой цаг хугацаа шаардах эсхүл хүлээх нөхцөл байдал үүсэж болдог. Тухайлбал, хөрөнгийн даатгагч тухайн эрсдэлийг хүлээн авахад шаардлагатай хангалттай мэдээлэл авч эрсдэлийг хүлээн авсан хэдий ч surveyor томилж эрсдэлийн тайлан гаргуулах, улмаар сайжруулж болох эрсдэлийн зөвлөмжүүдийг гэрээнд тусгахыг хүссэн. Ийм тохиолдлуудад, даатгагч cover note –г хэвлэж байж болдог. Даатгал хийгдсэн буюу даатгалын хамгаалалт хүчин төгөлдөр байгааг илтгэнэ.

Certificate of insurance: Зарим заавал даатгалын хэлбэрүүдэд, даатгалын гэрээ хүчин төгөлдөр байгаа гэдгийг нотлон харуулах хуулийн шаардлага байдаг бөгөөд үүнийг даатгалын сертификат хэвлэх замаар шийддэг.



Гэрээний тодорхой байх зарчим буюу contract certainty

Гэрээний тодорхой биш байдлуудаас шалтгаалж нөхөн төлбөрийн үед маргаан дагуулдаг муу практик Английн даатгалын зах зээлд тодорхой цаг үеүдэд илэрч байсан бөгөөд үүнээс үүдэлтэй underwriting at claims stage, deal now, detail later гэх мэт нэр томъёо хүртэл гарч байв.

Энэ практикыг халах, арилгах зорилгоор Английн даатгагчдын холбооноос Contract Certainty Rule гэх код гаргасан. Тухайлбал, даатгалын хэлцэл хийгдсэн тохиолдолд даатгалын гэрээ нэн даруй хэвлэгдэх ёстой, даатгалын гэрээ нь утга, агуулгын хувьд салаа утга санаа, өөрөөр тайлбарлаж болох өнцөг агуулга оруулсан байхыг хориглох, terms to be agreed гэх мэт тодорхойгүй нөхцөл, утга санаа гэрээнд огт ашиглахгүй байх гэх мэтчилэн кодчиллов.



Contract Certainty Rule - example

- Шаардлагатай мэдээ, мэдээллийг даатгуулагчаас шаардах эрхтэй
 - Даатгалын тохиолдол мөн эсэх болон хохирлын хэмжээг тогтооход ач холбогдолтой, үндэслэлтэй мэдээ мэдээллийг даатгуулагчаас шаардах эрхтэй
- Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирсан хохирлын шалтгаан нөхцөл, хэмжээг үнэн зөв тогтоохын тулд хууль, хяналтын байгууллага, цагдаа, галын байгууллага, эмнэлэг зэрэг мэргэжлийн эрх бүхий холбогдох байгууллагын хүмүүс оролцсон комиссоор акт тогтоолгох үүрэгтэй.



Contract Certainty Rule - example

Subject to wording to be agreed

Warranted the insured will install sprinkler system



Бүлэг

3. Даатгалын гэрээ, бичиг баримтын стандарт, практик

- Бүтэц, харагдах байдал, хэлбэр
- Скедул / Schedule
- Хасагдах Хэсэг / Exclusions
- Зохицуулалт нөхцөлүүд / General Conditions
- Warranty, Precedent Condition, Representations / Монголын даатгалын нөхцөл байдалд хэрхэн яаж ойлгож болох вэ?



Даатгалын гэрээний бүтэц

Даатгалын гэрээ буюу policy нь дараах 3 онцлогийг агуулна:

- Талуудын тохирсон ерөнхий нөхцөл тохиролцоо, заалтуудын дэлгэрэнгүйг агуулсан байх
- Parole evidence зарчим мөрдөх буюу гэрээнд тохиролцоогүй асуудлаар сүүлд маргахгүй
- Даатгалын гэрээ нь зөвхөн гэрээг нотлох бөгөөд даатгалын хэлцэл хийгдсэнийг батлахад шаардагдахгүй. the policy is only evidence of the contract and not the contract itself.

A policy is generally issued in a scheduled form.

Даатгалын гэрээ ихэвчлэн scheduled form хэлбэрээр хэвлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, Policy schedule + Policy wording гэсэн хэлбэртэй.

Policy schedule – Хувийн мэдээллийн хэсэг

Variable information буюу тухайн даатгалын зүйлтэй холбоотой хувьсах мэдээллүүдийг агуулдаг.

Policy wording - Гэрээний вординг

Pre-printed буюу урьдчилан бэлтгэсэн хэлбэртэй байдаг. Гэрээний стил, (style) нь тухайн даатгагчаас хамаарч ялгаатай байж болдог. Гэрээний хэмжээ (Length) нь гэрээний хэлбэрээс хамаарна.



Даатгалын гэрээний бүтэц

The ABI Statement of General Insurance Practice

Даатгалын гэрээ, бичиг баримт, документийг (proposal form and policy document) үг үсэг, утга агуулгын хувьд маш тодорхой (more clearly worded) болгох чиглэлд байнга хөгжүүлэлт хийхийг шаардана.

- Гэрээг тодорхой, өдөр тутмын (clear and everyday language) хэлээр бичих
- Даатгуулагчдад танил биш, төөрөгдүүлж болох үгс болон мэргэжлийн үг хэллэг (jargon) –ийн тайлбаруудыг оруулсан байх

The Consumer Insurance (Disclosure and Representations) Act 2012 :

Даатгагч даатгуулагчын даатгагчид мэдээлэл гаргаж өгөхдөө чин шударга байсан эсэхийг хянахдаа нөгөө талаас Даатгагч өөрөө харилцагч үйлчлүүлэгчдэд өгч буй нэмэлт материал, асуулгын хуудас зэргийнхээ тодорхой ойлгомжтой бөгөөд амар хялбар ойлгогдож байгаа эсэхийг байнга бодолцож байх үүрэгтэй.

The Insurance Act 2015 :

Гэрээний харилцаанд орохоос өмнө Даатгагч болон Даатгуулагч аль аль нь даатгалын гэрээний бүх нөхцөл, заалт, асуудал үүсэхэд шийдвэрлэх арга зам зэргийг тодорхой, ойлгомжтой байгааг нягтлах шаардлагыг тавьдаг.



Даатгалын гэрээний бүтэц

The Consumer Rights Act 2015 :

Хувь хүн буюу иргэдийн даатгалын гэрээний нөхцөл заалтуудыг илүү тодорхой байхыг, ялангуяа асуудал үүсэхэд даатгагч ямар эрхтэй болоод ямар арга замаар шийдэх нь маш ойлгомжтой тодорхой байхыг шаарддаг.

As clear and unambiguous as possible

Санамж: General rule: Гэрээнд хоёрдмол утгатай нөхцөл заалт үг утга оруулах нь даатгагчийн зорилго тодорхой бус байсан хэмээн түүний эсрэг тайлбарлагддаг. Үүнийг *'contra proferentem'* гэнэ.

Хэрэв гэрээний гол нөхцөлүүд (**core terms of insurance contract**) тодорхой, тунгалаг биш бөгөөд даатгуулагчийн анхаарлыг татахуйц биш (**not transparent and prominent**) байсан бол үүнийг **unfairness буюу шударга, ил тод бус** байсан гэж үзнэ.

- Expressed in plain and intelligible language
- Be adequately brought to the insured's attention

Ambiguity in contract language

Claim Case – Machinery Breakdown due to electric short circuit

Coverage – Machinery and Computer Breakdown extension clause

It is agreed and understood that otherwise subject to terms, exclusions, provisions and conditions contained in the policy or endorsed thereon

Exclusion – mechanical or electrical breakdown or derangement of machinery or equipment including electronic installations computers and data processing equipment



Даатгалын гэрээний бүтэц

Даатгалын гэрээний энгийн бүтэц нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Толгой хэсэг / Heading
- Удиртгал / Preamble or recital clause
- Гарын үсэг баталгаажуулах хэсэг / Signature clause
- Амлалт хэсэг /Operative clause known as the insuring clause/
- Хасалт хэсэг /general exclusions and specific exclusions/
- Болзолт нөхцөлүүд /conditions/
- Скедул буюу эрсдэлийн хувийн мэдээллийн хэсэг / Policy Schedule
- Мэдээллийн хэсэг буюу нэр томъёо, санал гомдол гэх мэт. / Information and Facilities



MRC – London Market Slip гэрээний олон улсад түгээмэл тогтсон бүтэц хам даатгал, хам давхар даатгалын харилцаанд тохирсон, сүпер бүтэц

Risk Details – хувьсах мэдээллүүд. Тухайн хэлцлийн гол ба тохиролцсон мэдээллүүд

Information – эрсдэлийн мэдээллүүд – андеррайтерт ямар ямар мэдээллүүд гаргаж өгсөн тухай etc

Subscription Details – эрсдэлийг бичсэн андеррайтеруудын гарын үсэг зурж, тамгаа дардаг хэсэг

Subscription Agreement – андеррайтеруудын харилцаа, гэрээний операцийн гол зохицуулалтууд. Жишээлбэл, даатгалын тохиолдлыг шийдэх үйл явцад аль нэг андеррайтер толгойлж бусад андеррайтерууд дагах юм уу?

Regulatory – хууль, зохицуулалт, нийцэлтэй холбоотой шаардагдах зүйлсийг энд тусгана

Deductions – гэрээний зардлууд /брокерын шимтгэл, давхар даатгуулагчийн комисс, татвар, эрсдэлийн үнэлгээний ажлын зардал, бусад хямдруулалт гэх мэт/

Policy Condition – даатгалын гэрээний нөхцөлүүд /Schedule and Conditions/



Хам даатгалын жишээ

	TSI	150											
75	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	300,000
50	Emirates (60% of 50 xs of 25)						SCOR (40% of 50 xs of 25)					75,000	
25	Swiss Re (30% of 25 xs of ded)		Hannover Re		Trans Re	AWAC	Everest	Arch	Emerald				225,000



COVERHILL

Коверхилл Даатгал, Давхар Даатгалын Брокер
цахим хаяг: enkhtaivan@coverhill.mn
холбогдох утас: 80088669

2023 оны ... сарын ...

Гэрээний дугаар:

АГУУЛГА

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ СКЕДЮЛ.....	3
ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ВОРДИНГ	4
1. Даатгалын хамгаалалт	4
2. Нэхэмжлэл шийдвэрлэх нөхцөл.....	4
2.1. Тохиолдлыг цаг алдалгүй мэдэгдэх тухай	4
2.2. Баримт материал, нотолгоо гаргаж өгөх үүрэг	4
2.3. Гэм бурууг хүлээн зөвшөөрөх эсэхтэй холбогдох зохицуулалт	4
2.4. Даатгуулагч даатгагчид туслалцаа үзүүлж, хамтарч ажиллах үүрэг	5
3. Бусад зохицуулалтууд	5
3.1 Хураамж төлөлт	5
3.2 Даатгал шаардах.....	5
3.3 Эрх шилжүүлэх.....	5
3.4 Гэрээг цуцлах	5
3.5 Буруу ташаа мэдээлэл, луйвар залилан	6
3.6 Гэрээний үл ойлголцлыг арбитраар шийдэх.....	6
3.7 Бусад даатгал.....	6
4. Хасагдах хэсэг.....	6



Даатгалын гэрээний бүтэц

АМЛАЛТЫН НӨХЦӨЛ / OPERATIVE CLAUSE KNOWN AS THE INSURING CLAUSE

Уг хэсэг нь даатгалын гэрээний хамгийн гол хэсэг буюу даатгалаар юуг хэрхэн төлөх тухай даатгагчийн амласан амлалтыг тусгасан заалт юм. Даатгалын гэрээний хамгаалалтын хэсэг тус бүрт амлалтын нөхцөл байж болдог.

Жишээ нь:

‘ To indemnify the insured against any claim(s) first made against the insured during the period of insurance in respect of any legal liability arising (including liability for claimants’ costs) incurred in connection with the insured’s business.’



Амлалт хэсэг - OPERATIVE CLAUSE KNOWN AS THE INSURING CLAUSE

COVERHILL

Коверхилл Даатгал, Давхар Даатгалын Брокер
цахим хаяг: enkhtaivan@coverhill.mn
холбогдох утас: 80088669

2023 оны ... сарын ...

Гэрээний дугаар:

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ВОРДИНГ

1. Даатгалын хамгаалалт

- 1.1. Түрээслүүлэгч, Үйлчлүүлэгч, аливаа гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирч, үүндээ даатгуулагчийг буруутай гэж үзэн, даатгуулагчийн эсрэг гэм хор, хохирлыг барагдуулахыг шаардсан нэхэмжлэл гаргаж, үүнд даатгуулагч хариуцлага хүлээх үндэслэлтэй байх аваас даатгагч үүссэн гомдол, нэхэмжлэлийг даатгуулагчийн өмнөөс хариуцаж энэхүү гэрээнд тусгасан нөхцөл, зохицуулалтад нийцүүлж үүссэн гэм хор, хохирлоос даатгуулагчийг чөлөөлж, нөхөн төлбөр олгоно.
- 1.2. Даатгуулагчийн эсрэг үүссэн түрээслүүлэгчийн, үйлчлүүлэгчийн, аливаа гуравдагч этгээдийн гомдол, нэхэмжлэлийг даатгуулагчийн нэрийн өмнөөс судлах, даатгуулагчийг өмгөөлөх, хохирогч талтай зөвшилцөх, тохиролцох, нэхэмжлэлийг үл зөвшөөрөх, хариу арга хэмжээ авах зэрэг хууль зүйн мэргэжлийн туслалцаа үйлчилгээ болон хохирлыг үнэлж тулган баталгаажуулах хохирол үнэлгээчин зэрэг бусад холбогдох мэргэжлийн туслалцаа үйлчилгээний зардлыг даатгалын нөхөн төлбөрөөс гадна даатгагч хариуцаж төлнө.



Даатгалын гэрээний бүтэц

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ / POLICY SCHEDULE

Даатгуулагч болон даатгалын зүйлийн талаарх хувийн, тусгай мэдээллүүд. Variable part буюу хувьсаж өөрчлөгдөх мэдээллүүд энэ хэсэгт багтана. Тухайлбал:

- Даатгуулагчийн нэр, хаяг
- Гэрээний хугацаа, хураамж
- Даатгалын зүйлийн мэдээлэл
- Үнэлгээ, хариуцлагын хязгаар
- Гэрээний дугаар
- Тусгайлан хасагдах хэсэг, болзолт нөхцөл, хамгаалалтын хүрээ зэргийн талаарх мэдээлэл. Модулер форм.
- Бүс нутаг, газарзүй
- Шүүх эрх мэдэл буюу jurisdiction

Даатгалын гэрээний бүтэц

БУСАД МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ / INFORMATION AND FACILITIES

Энэ хэсэгт гэрээний бусад туслах заалт, мэдээллүүд багтдаг. Тухайлбал:

- Нэр томъёоны тайлбар
- Харилцагчийн үйлчилгээний стандартын тухай мэдэгдэл
- Санал гомдол хүлээн авах ба шийдвэрлэх процесс
- Нөхөн төлбөрийн үед авах арга хэмжээ буюу what to do жагсаалт гэх мэт



Даатгалын гэрээний бүтэц

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ / POLICY SCHEDULE

Хувийн мэдээллийн хэсэгт гэрээний нөхцөл болон хасагдах хэсгүүдийг дурьдана. Хасагдах хэсгүүдийн хувьд **модулер форм** –д оруулсан байдаг. Тухайлбал:

- Sanctions Limitation & Exclusion Clause LMA 3100
- Terrorism Exclusion Endorsement NMA 2921,
- Nuclear Energy Risks Exclusion Clause NMA 1975A,
- War and Civil War Exclusion clause NMA 464
- Infectious Disease / Covid -19 Exclusion clause
- Property Cyber and Data Exclusion LMA5401

Subscription market –н хувьд Market Reform Contract (MRC) слип гэрээ ашигладаг ба хувийн мэдээллийн хэсэгт өөр олон мэдээллүүд агуулдаг.

Source of wording and clauses

- LSW – London Standard Wording
- LMA – Lloyd's Market Association
- NMA – Non-Marine Association
- AVN – Aviation market

Даатгалын гэрээний бүтэц

ХАСАГДАХ ХЭСЭГ / EXCLUSIONS

Дараах 2 төрлийн хасагдах хэсэг байдаг.

- **General exclusions:** Даатгалын гэрээний бүх хэсэгт хамааралтай ерөнхий хасагдах хэсгүүд. Market exclusion эсхүл absolute exclusion гэж заримдаа нэрлэдэг.
- **Specific exclusions:** Даатгалын гэрээний тодорхой хэсэгт хамаарч үйлчлэх тусгайлсан хасагдах хэсгүүд. Тухайлбал, хариуцлагын даатгалын зөвхөн бүтээгдэхүүний хариуцлагын хэсэгт хамаарах хасагдах хэсэг гэх мэт.

Ердийн даатгалын бүхий л гэрээнд нийтлэг үйлчилдэг хасагдах хэсгүүд байдаг бөгөөд тэдгээрийг market exclusions гэдэг. Эдгээрт дараах хасагдах хэсгүүд багтана.



Даатгалын гэрээний бүтэц

ХАСАГДАХ ХЭСЭГ / EXCLUSIONS

MARKET EXCLUSIONS

- **War and related perils:** Fundamental эрсдэл гэж үздэг. Гэхдээ бүх fundamental эрсдэлүүд даатгагдахгүй биш. Тухайлбал газар хөдлөлт нь fundamental эрсдэл хэдий ч даатгагдаг эрсдэл юм. Мөн дайны эрсдэл ч зарим төрлийн гэрээгээр даатгагдана. Тухайлбал, aviation болон marine даатгалаар дайны эрсдэл даатгагддаг.
- **Radioactive contamination and explosive nuclear assemblies:** Мөн fundamental эрсдэл гэж үзнэ. Market pool механизмаар зарим тохиолдолд даатгагдаж болно.
- **Terrorism:** Мөн fundamental шинжтэй бөгөөд дагуулах хохирлын хувьд дан ганц даатгагч даах боломжгүй түвшинд байна. Since the terrorist attack on the World Trade Center in New York on 11 September 2001, терроризм хөрөнгийн төрлийн бүх гэрээнээс хасагдсан. Гэхдээ даатгуулагч хүсвэл терроризмын эрсдэлийг гэрээнд оруулж болох бөгөөд тодорхой шаардлагууд тавигдана.
- **Pollution and/or contamination:** Хөрөнгийн даатгалын стандарт хасалт. Гэхдээ pollution and contamination нь гэрээнд заасан эрсдэлээс шалтгаалж үүссэн эхсүл гэрээнд заасан эрсдэл үүсэх шалтгаан болсон бол даатгалд хамрагдаж болно. Хариуцлагын даатгалын тухайд unexpected, identifiable event даатгагдаж болно. Харин аажмаар үүссэн бохирдол (gradual pollution) хамаардаггүй.

Даатгалын гэрээний бүтэц

ХАСАГДАХ ХЭСЭГ / EXCLUSIONS

MARKET EXCLUSIONS

- **Cyber risk:** Хөрөнгийн даатгалын хасагдах хэсэгт багтдаг. Тусдаа даатгалын бүтээгдэхүүн болон хөгжиж байгаа. Property Cyber and Data Exclusion LMA5401
- **Marine policy:** Стандарт хөрөнгийн даатгалын гэрээний хасагдах хэсэгт marine policy –гоор даатгагдсан хөрөнгүүдийг хасалтад оруулдаг. Гэхдээ marine policy is insufficient, хөрөнгийн даатгалын гэрээн давсан хэсэгт үйлчилнэ.
- **Contractual liability: Зөвхөн тухайн гэрээний хүрээнд үүсэх хариуцлага.** Өөрөөр хэлбэл, бусад хууль тогтоомж, тухайлбал гэм хорын тухай хууль, common law зэрэгт заагдаагүй боловч зөвхөн тухайн гэрээг байгуулсан учраас хүлээж болох хариуцлагууд
- **Sonic bang:** Дууны хурдаар аялах нисэх онгоц болон бусад нисэх төрөөхөмжүүдийн даралтын долгионоос үүсэх хохирлууд стандарт хөрөнгийн гэрээний хасагдах хэсэгт багтдаг.

Даатгалын гэрээний бүтэц

ХАСАГДАХ ХЭСЭГ / EXCLUSIONS

ХӨРӨНГИЙН ДААТГАЛЫН ХАСАГДАХ ХЭСЭГ / EXCLUSIONS OF COMMERCIAL PROPERTY POLICY

1	Absolute exclusions	War, pollution, contamination and consequential loss etc.
2	Gradually operating exclusions	Corrosion or rust, wind or rain damage to property in the open
3	Excluded property	Money, glass, jewelry, fur etc.,
4	Property or risks more appropriate to another class of business	Motor vehicle or aircraft etc.,



Даатгалын гэрээний бүтэц

БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД / CONDITIONS

Гэрээний үүрэгжүүлсэн нөхцөлүүд байдаг. Даатгуулагч талаас гэрээний туршид дагаж мөрдөх, биелүүлэхээр зөвшилсөн нөхцөлүүд.

Болзолт нөхцөлүүд нь express or implied гэсэн 2 хэлбэрээр байж болно.

Express: гэрээнд байнга тусгагддаг нөхцөлүүд

Implied: гэрээнд заагаагүй хэдий ч хэн бүхэн дагаж мөрдөх ёстой нөхцөлүүд

- Тухайлбал, даатгуулагч даатгалын гэрээ аваагүй мэт даатгалын зүйлийн аюулгүй байдлыг хангаж байх шаардлагатай ба даатгалын гэрээ байгуулсаныг даатгалын зүйлдээ хайхрамжгүй тоомжиргүй хандах шалтгаан болгохгүй байх
- Хуулийн заалтууд



Даатгалын гэрээний бүтэц

БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД / CONDITIONS

- Даатгуулагчийн үүргүүд / Duties of the insured
- Гэрээнд өөрчлөлт оруулах тухай / Alteration
- Даатгалын тохиолдолын үед даатгуулагчийн авах арга хэмжээ / Actions by the insured in the event of a claim
- Луйвар, залилан / Fraud
- Хохирол тохиолдох магадлалыг бууруулахаар авах боломжит арга хэмжээ / Reasonable precautions
- Давхардсан даатгалыг зохицуулах тухай / Contribution/
- Буцаан нэхэмжлэх эрх / Subrogation
- Дундаж тооцох тухай / Average
- Арбитр, шүүх / Arbitration
- Гэрээг цуцлах / Cancellation



Даатгалын гэрээний бүтэц

БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД / CONDITIONS

Даатгуулагчийн үүргүүд / Duties of the insured

Гэрээний хугацаанд даатгуулагчийн дагаж, мөрдөх, сахин биелүүлэх ёстой үүргүүд.

Гэрээнд өөрчлөлт оруулах тухай / Alteration

Duty of disclosure –г үргэлжлүүлэн биелүүлэх тухай болон эрсдэл тохиолдох магадлалыг өсгөж болох аливаа шаанс, нөхцөл байдлын талаар даатгагчид мэдэгдэх үүргийг энэ хэсгээр оногдуулдаг.

Даатгалын тохиолдолын үед даатгуулагчийн авах арга хэмжээ / Actions by the insured in the event of a claim

Даатгалын хэлбэрээсээ хамаараад өөр өөр байж болох хэдий ч даатгалын тохиолдлын үед мэдэгдлийг ямар хугацаанд өгөх, ямар арга замаар мэдэгдэл өгөхийг заасан байна.

Луйвар, залилан / Fraud

Залилах хууран мэхлэх замаар хуурамч нөхөн төлбөр авсан, авахыг завдсан тохиолдолд гэрээний дагуу нөхөн төлбөр авах даатгуулагчийн эрх хүчингүй болох тухай заадаг.



Даатгалын гэрээний бүтэц

БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД / CONDITIONS

Хохирол тохиолдох магадлалыг бууруулахаар авах боломжит арга хэмжээ / Reasonable precautions

Даатгалын зүйлийн аюулгүй байдлыг хангах, хохирол тохиолдох нөхцөл, магадлыг бууруулж байх тухай болон даатгуулагч даатгалын гэрээг даатгалын зүйлд хайхрамжгүй хандах шалтаг болгохгүй байх тухай заадаг. Гэхдээ хуулиар ийм заалт гэрээнд оруулахыг хориглоогүй хэдий ч нөхөн төлбөрийн маргааны үед шүүх энэ заалтыг төдийлөн ашигладаггүй.

Дундаж тооцох тухай / Average condition

Special condition average

Арбитр, шүүх / Arbitration

Маргаан шийдвэрлэх тухай заалт, ихэвчлэн loss quantum dispute буюу хохирлын хэмжээн дээр маргах маргааны тухай байдаг. Гэхдээ маргааныг шийдвэрлэх өөр аргачлалууд байж болно. Financial Ombudsman Services



Даатгалын гэрээний бүтэц

БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД / CONDITIONS

Давхардсан даатгалыг зохицуулах тухай / Contribution

Нэг хохирол, нэг даатгалын зүйл нь өөр өөр гэрээгээр давхардаж даатгасан нөхцөлд бусад даатгалын компаниудыг тухайн хохирлоос хувь тэнцүүлэн төлөхийг шаардах даатгагчийн эрхб

- Common insurable interest: Owner, user, bailee
- Common peril: Хохирол үүсгэсэн шалгаан буюу peril нь даатгалын гэрээ тус бүрт багтсан байх
- Common subject-matter: Хохиролд өртсөн даатгалын зүйл гэрээ тус бүрт ижил байх
- Both policies are liable for the loss: Гэрээ тус бүр тухайн хохирлыг төлөх боломжтой байх
- Neither policy contains a non-contribution clause: Гэрээ тус бүр non-contribution clause агуулаагүй байх.

Rate-able proportion

- By sum insured =
$$\frac{\text{Policy sum insured}}{\text{Total sums insured}} \times \text{Loss}$$

- By independent liability =
$$\frac{\text{Independent liability under the policy}}{\text{Total of independent liabilities under all policies}} \times \text{Loss}$$

Даатгалын гэрээний бүтэц

БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД / CONDITIONS

Буцаан нэхэмжлэх эрх / Subrogation

Нөхөн төлбөр олгосны дараа хохиролд буруутай байх гуравдагч талаас хохирол нэхэмжлэх даатгуулагчийн эрхийг өөртөө авах даатгагчийн эрх.

- Mutual hold harmless agreement
- Benefit policies: No right of recovery
- Subrogation waiver
- Negligent fellow employees



Даатгалын гэрээний бүтэц

БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД / CONDITIONS

Гэрээг цуцлах / Cancellation

Гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах тухай заалтууд. Гэрээг цуцлах даатгагчийн эрхийг тухайлбал, Consumer Insurance Act, Insurance Act –уудаар хатуу хянадаг. Ялангуяа mid-term cancellation. 14-30 хоногийн өмнөөс мэдэгдэх эсхүл даатгагч гэрээнээс татгалзаж болох нөхцөлүүдийг хязгаарласан байдаг. Мөн үндсэн гэрээ цуцлагдаж байгаа бол түүнийг дагуулж хийсэн cross-sold coverages хамт цуцлагдах ёстой.

Даатгуулагчийн хувьд: гэрээ эхэлсэн эсхүл гэрээний сунгалтаас 14 хоногийн өмнө гэрээг цуцлах эрх олгодог. Cooling off period буюу даатгуулагч даатгалын гэрээний талаарх санал шийдвэрээ өөрчилж болох хугацаа юм.

Short rate cancellation

Pro-rata cancellation

No refund



Даатгалын гэрээний бүтэц

WARRANTIES, CONDITIONS AND REPRESENTATIONS

Warranties гэдэг бол тухайн эрсдэлийн талаар даатгуулагчаас өгч буй

- Ямар нэг зүйл хийнэ эсхүл хийхгүй
- Тодорхой факт оршин байгаа эсхүл байхгүй тухай амлалтууд байдаг. Жишээ нь:

Далайн даатгал:	Хөлөг онгоц тодорхой бүс нутгуудаас аялахгүй байх
Хөрөнгийн даатгал:	Даатгуулж буй барилга бүтэн үйл ажиллагаатай бороожуулагч системээр хамгаалагдсан байна.

Warranties буюу амлалтыг даатгагч эрсдэлийн хамгийн чухал гэж үзэж буй онцлог (aspects) –уудыг хянах зорилгоор ашигладаг ба warranty –г зөрчвөл авах арга хэмжээг хуулиар зааж өгсөн байдаг.

Warranty зөрчсөн нь хохирол үүсэх шалтгаан болоогүй бол нөхөн төлбөрөөс татгалзахгүй. Гэхдээ warranty зөрчигдсэн үед зөрчлийг арилгах хүртэл даатгалын гэрээний үйлчлэл түр хугацаанд зогсож, зөрчил арилмагц эргээд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Даатгалын гэрээний бүтэц

УГТВАР НӨХЦӨЛ / CONDITION PRECEDENTS

Гэрээний угтвар нөхцөлүүдийг дараах 3 бүлэгт хувааж болно.

Condition precedent to the contract	Даатгалын гэрээний суурь угтвар нөхцөлүүд. Тухайлбал, даатгалын сонирхол гэх мэт гэрээ хүчин төгөлдөр байх суурь шаардлагууд энд хамаарна.
Condition subsequent to the contract	Даатгалын гэрээ байгуулагдмагц түүнийг дагах угтвар нөхцөлүүд. Тухайлбал, даатгалын зүйлийн өөрчлөлтийн талаар мэдэгдэл өгөх гэх мэт
Conditions precedent to liability (or recovery)	Нөхөн төлбөр үүрэг хүлээхэд тавигдах угтвар нөхцөлүүд. Тухайлбал, даатгалын тохиолдлыг нэн даруй мэдэгдэх гэх мэт

Болзолт нөхцөлүүдийг зөрчвөл үүсэх үр дагавар, хариуцлага нь эдгээр болзолт нөхцөлүүдийн аль бүлэгт багтаж байгаагаас хамаардаг.



Даатгалын гэрээний бүтэц

REPRESENTATION

Duty of disclosure, duty to make a fair presentation зэрэг даатгуулагч талд оногдуулсан даатгагчийг мэдээллээр хангах тухай үүрэг байдаг. Үүнийг representation гэдэг ба representation нь үнэн зөв бөгөөд бүрэн дүүрэн байхыг шаарддаг.

Мэдээллийг буруу гаргаж өгсөн тохиолдолд авах арга хэмжээг мөн Consumer Insurance Act болон Insurance Act гэсэн хуулиудаар зохицуулсан байдаг. Худал буруу мэдээлэл гаргаж өгсөн нь санаатай эсхүл санамсаргүй байснаас хамаарч даатгагчийн авах арга хэмжээг ялгаатай байдаг.

Хэрэв санаатайгаар худал хуурмаг мэдээлэл гаргаж өгсөн бол	Хайхрамжгүйгээр буруу мэдээлэл өгсөн бол
Даатгагч гэрээнээс татгалзах эрхтэй.	Хэрэв хэрэглэгч зөв мэдээлэл ирүүлсэн бол даатгагч ямар шийдвэр гаргах байсан бэ гэдгээс хамаардаг. <ul style="list-style-type: none">✓ Хэрэв даатгагч гэрээ хийхгүй байсан бол гэрээг цуцалж болох бөгөөд хураамжийг буцаах ёстой.✓ Хэрэв даатгуулагч гэрээг өөр нөхцөлөөр байгуулах байсан бол даатгагч тухайн гэрээг тухайн нөхцөлүүд үйлчлэх байдлаар авч үзэж болно.✓ Хэрэв даатгуулагч илүү өндөр хураамжтайгаар гэрээг байгуулах байсан бол нөхөн төлбөрийг хувь тэнцүүлэн бууруулж болно.

Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

Rating Factors

Даатгалын зах зээлд нөлөөлөгч маш олон хүчин зүйлс бий. Эдгээр хүчин зүйлс, факторуудын зарим нь даатгалын компанийн хяналтад байх хэдий ч тэдний хяналтаас гадуур оршдог олон хүчин зүйлс бас бий.

Харилцагч, үйлчлүүлэгчдийн нөхөн төлбөрийг төлөх нь даатгалын компанийн гол шаардлага хэдий ч нөгөө талаас хувьцаа эзэмшигчид, эзэд, хяналт зохицуулалтын байгууллагуудаас тавигдаж буй шаардлагыг биелүүлэх хэрэгцээ шаардлагууд тулж байдаг. Гол шаардлагын нэг нь ашигтай ажиллах.


Энэ зорилгод хүрч, нийцэж ажиллахад өргөн хүрээний төлөвлөгөө шаардагдах бөгөөд ийнхүү төлөвлөхөд гүйцэтгэлийн дата, мэдээлэл маш чухал үүрэгтэй байна. Энэхүү хэрэгцээт мэдээллийг management information (MI) гэнэ.

MI нь компанийн ирээдүйн гүйцэтгэлийг таамаглах, андеррайтингийн шийдвэр гаргах, ялангуяа хураамжийн рэйт, үнэ тооцоолоход чухал үүрэгтэй.



Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

Дата: Мэдээлийн гурвалжин / Information Pyramid



Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

Дата: Мэдээлийн гурвалжин / Information Pyramid

Удирдах зөвлөлд шаардагдах мэдээллүүд / Board level reporting

Групп, компанийн хэмжээн дэх гүйцэтгэл, ашигт ажиллагаа, нөгөө талаас компанийн хэмжээний эрсдэл (downside risk) –ийн хяналт тухайлбал, nat cat reinsurance etc., стратегийн хэрэгжилт гэх мэт.

- Өсөлт: Нийт болон цэвэр хураамжийн өсөлт
- Хохирлын харьцаа: Нийт болон цэвэр хохирлын харьцаа
- Андеррайтингийн ашиг, margin
- Бичиж буй эрсдэлийн багц / business mix: Даатгалын хэлбэр, борлуулалтын суваг, бүс нутаг
- Эрсдэлийн хуримтлал / Exposure accumulations: Нэг төрлийн бизнес лайнд хэтэрхий их төвлөрч бичсэн, түүнээс үүсэх өртөц, эрсдэлийн хуримтлал бий болж буй эсэх
- Өрсөлдөөний байр суурь / Competitive positioning:
- Хөрөнгийн өгөөж / Return on capital
- Төлбөрийн чадвар / Solvency:

Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

Дата: Мэдээлийн гурвалжин / Information Pyramid

Андеррайтинг менежерт шаардагдах мэдээллүүд / Reporting to underwriting managers

Бизнесийн хэлтэс тус бүрийн гүйцэтгэл мэдээллүүд. Ихэвчлэн сарын давтамжтайгаар мэдээллүүдийг авч харах ба гол анхаарах зүйл нь тренд буюу ерөнхий хандлага хаашаа чиглэж байгааг анзаарах тухай байдаг.

- Өсөлт: Бүтээгдэхүүн тус бүрийн хувьд
- Retention rate: Харилцагчдыг ямар түвшинд хадгалж үлдэж байгаа вэ?
- Шинэ бизнесийн боломж
- Алдагдсан бизнесийн анализ
- Хохирлын харьцаа: Нийт болон цэвэр хохирлын харьцаа
- Нөхөн төлбөрийн тренд / Claims trend: Frequency and severity, нэг нөхөн төлбөрийн дундаж зардал
- Underlying claims
- Томоохон хохирлууд: Frequency and severity
- Цаг уур, байгалийн хүчин зүйлээс шалтгаалсан нөхөн төлбөрүүд: Frequency and severity

Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

Дата: Мэдээлийн гурвалжин / Information Pyramid

Андеррайтинг менежерт шаардагдах мэдээллүүд / Reporting to underwriting managers

- Нөөц сангийн тогтвортой байдал / Reserve consistency
- Рэйтийн өөрчлөлт ба эцсийн хэрэглэгчид очиж буй үнийн өсөлт
- Commission rate
- Зардлын харьцаа / Expense ratios
- Эрсдэлийн хуримтлал / Exposure accumulations: Нэг төрлийн бизнес лайнд хэтэрхий их төвлөрч бичсэн, түүнээс үүсэх өртөц, эрсдэлийн хуримтлал бий болж буй эсэх
- Өрсөлдөөн ба зах зээлд эзлэх хувь шэйр



Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

Дата: Мэдээлийн гурвалжин / Information Pyramid

Үйл ажиллагааны мэдээллүүд / Operational data

Энэ түвшинд мэдээллийг илүү ойр давтамжтайгаар шинэчлэн харах шаардлагатай бөгөөд агент, брокер, даатгалын хэлбэр болон андеррайтинггаар ялган харах хэрэгтэй.

- Хохирлын харьцааны статистик / frequency/severity/large losses/claims movements;
- Шинэ бизнес / New Business;
- Рэйтийн өсөлт / Rate increases;
- Харилцагчаа хадгалж буй байдал / Retention
- Хураамжийн авлагын хяналт / Credit control
- Гэрээний тодорхой байх стандартын нийцэл / Compliance with certainty



Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ / IMPORTANCE OF CLAIMS INFORMATION

Нөхөн төлбөр бол үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үндсэн зардал. Тиймээс андеррайтингийн ашигт ажиллагааг тооцоход өнгөрсөн хугацааны нөхөн төлбөрийн мэдээллийг анализ хийх нь хамгийн чухайл.

- Trend
- Future loss pattern

Дараах гол асуултуудын хүрээнд анализ хийгдэнэ.

- Жил бүрийн нөхөн төлбөрийн мэдээллээс, жилээс жилд нөхөн төлбөрийн тренд хандлага сайжирч эсхүл муудаж байна уу?
- Жилээс жилд нөхөн төлбөрийн тоо өсөж байна уу? Том дүнтэй болон жижиг дүнтэй нөхөн төлбөрүүдийн хувьд? (volume)
- Нөхөн төлбөрийн голлох шалтгаанууд юу байна?
- Нөхөн төлбөрийн нормал трендийг эвдэж буй томоохон кэйсүүд байна уу?
- Нөхөн төлбөрийн нэхэмжлэл бүрт зориулан үүсгэж буй нөөц зөв эсэх? Given the nature of the claim.
- Төлөгдөөгүй байгаа нөхөн төлбөрүүдийн тухайд ямар статустай байгаа тухай?
- Нөхөн төлбөрийн мэдээллүүд хэрхэн хадгалагддаг вэ? Year of notification; or underwriting year

Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

НӨХӨН ТӨЛБӨРИЙН ДАВТАМЖ БА ЦАР ХҮРЭЭ / FREQUENCY AND SEVERITY OF CLAIMS

High frequency and low severity: Олон тооны жижиг хохирлууд гарах ба том хэмжээний цөөн хохиролтой.

- Suitable excess чухал
- Underlying claims cost гэж үзнэ
- Ийм төрлийн хохирлын зардлыг урьдчилан тодорхой хязгаар хүртэл андеррайтерууд тооцсон байдаг. Жишээ нь, хөрөнгийн даатгалын нийт хураамжийн 20% - 25% хооронд жижиг хохирлууд төлнө гэх мэт.

Low frequency and high severity: Тохиолдол цөөн боловч хохирлын зардал маш өндөр.

- Таамаглахад маш хэцүү;
- Big volatility үүсгэдэг
- Давхар даатгалын хэрэгцээ шаардлага өндөр



Даатгалын хураамж буюу үнэ тооцоолох суурь техник

НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХАРЬЦААНУУД

Claims loss ratios:

Тухайн аккаунт болон нийт багцийн гүйцэтгэлийг дүгнэх гол үзүүлэлт.

Earned loss ratio (ELR):

Орлогод тооцсон хураамжийн харьцаа: Тухайн аккаунтын хувьд давхар даатгалын зардал, IBNR зэргийг бодолцож харьцааг өөрчилж болдог.

2023 оны 7 сарын 1 нд гэрээ эхэлсэн бөгөөд 1000 долларын хураамжтай гэвэл энэ даатгалын тухайн санхүүгийн жилд бодох орлогод тооцсон хураамж хэд вэ?

Outstanding loss ratio (OLR)

- Underlying claims cost гэж үзнэ
- Ийм төрлийн хохирлын зардлыг урьдчилан тодорхой хязгаар хүртэл андеррайтерууд тооцсон байдаг. Жишээ нь, хөрөнгийн даатгалын нийт хураамжийн 20% - 25% хооронд жижиг хохирлууд төлнө гэх мэт.

Low frequency and high severity: Тохиолдол цөөн боловч хохирлын зардал маш өндөр.

- Таамаглахад маш хэцүү;
- Big volatility үүсгэдэг
- Давхар даатгалын хэрэгцээ шаардлага өндөр

Main Elements of the premium / Хураамжийн гол бүрдэл хэсгүүд

Risk Premium

Expenses

Profit

Return on Capital
Employed
(ROCE)

Risk Premium

- Даатгалын үйл ажиллагааны гол өртөг зардал.
- Худалдааны бизнесээр зүйрлэвэл борлуулалтын өртөг гэж үзэж болно. Жишээлбэл, автомашин импортлож эцсийн худалдан авагчид борлуулдаг үйл ажиллагааг харвал автомашиныг худалдах үнэ тухайн автомашиныг нийлүүлэгчээс авахад төлсөн өртөг зардал + үйл ажиллагааны зардал + цэвэр ашиг гурвын нийлбэр байдаг билээ.
- Даатгалын хувьд тэгвэл риск премиум нь нийт нөхөн төлбөрт төлөх төлбөр юм. Даатгагч энэхүү дүнг одоо бодож тооцсон байх ёстой.
- Риск премиум тэгэхлээр нийт нөхөн төлбөрийг төлж чадах хангалттай хэмжээтэй байхаар тооцогдсон байх учиртай.



Даатгалын бүтээгдэхүүн тус бүрт андеррайтингийн авч үзэх асуудлууд

Хувь хүний даатгал

1. Тээврийн хэрэгслийн даатгал
2. Орон байрны даатгал /household insurance/
3. Хөрөнгийн даатгал
4. Бизнес тасалдлын даатгал
5. Ажил олгогчийн хариуцлагын даатгал

Байгууллагын даатгал

6. Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын даатгал + Бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлагын даатгал + Бохирдлын хариуцлагын даатгал
7. Мэргэжлийн хариуцлагын даатгал
8. Удирдах ажилтны хариуцлагын даатгал
9. Цахим аюулгүй байдлын даатгал /cyber insurance/

Хувийн тээврийн хэрэгслийн даатгал:

Их Британи-д дараах 4 төрлийн даатгалын хамгаалалтыг санал болгодог:

- Road Traffic Act only
- Гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага /Сайн дурын жолоочийн хариуцлага/
- Гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, Гал, Хулгай
- Иж бүрэн хамгаалалт /comprehensive/

Road Traffic Act 1988 хуулиар тээврийн хэрэгслийн эзэмшигч бүр заавал даатгалтай байхыг шаарддаг ба нэмэлтээр тээврийн хэрэгслийг барих жолоочийг нэрлэдэг. Уг хуулийн шаардлагын дагуу хамгийн энгийн даатгалын хамгаалалт нь Road Traffic Act only хамгаалалт ба энэ нь бусдын амь нас, эрүүл мэндийн өмнө хүлээх хариуцлагын хэмжээ хязгааргүй, эд хөрөнгийн хохиролд 1.2 сая паунд байх ба эмнэлэг эмчилгээний зардал, түргэн тусламжийн зардал, тээврийн хэрэгсэлгүй үед гарах нэмэлт зардлуудыг төлөх байдаг.

Гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага /Сайн дурын жолоочийн хариуцлага/ нь дээрх дурдсан хамгаалалт дээр дараах зүйлс нэмэгддэг:

- Бусдын эд хөрөнгийн хохиролд төлөх дүн 20 сая паунд хүртэл
- Хэрвээ байгууллагын тээврийн хэрэгсэл бол тухайн байгууллагын ажилтанд хамгаалалт үйлчилнэ
- Зорчигчдод учирсан хохирлын өмнө хүлээх хариуцлагад нөхөн төлбөр олгоно
- Нэхэмжлэлтэй холбоотой хуулийн үйлчилгээний зардал төлнө

Хувийн тээврийн хэрэгслийн даатгал:

Гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, Гал, Хулгай нь өмнө дурдсан хамгаалалт дээр өөрийн тээврийн хэрэгслийг хулгайлах, хулгайд өртөх, хулгай хийх үед үүссэн гэмтэл, хохирол; гал, тэсрэлт дэлбэрэлт, аянга цахилгаанаас үүдсэн галын хохиролд нөхөн төлбөр олгох байдаг.

Иж бүрэн хамгаалалт нь бүх эрсдэл нөхцөлтэй даатгалын хамгаалалт байх ба хасагдах ерөнхий нөхцөлд дараах зүйлс орно:

- элэдгдэл хорогдол
- үнэлгээний бууралт
- тээврийн хэрэгсэл эвдэрсэнээс үүсэх бусад зардал /loss of use/
- механик, цахилгааны алдаа
- дугуй цоорох хагарах, дэлбэрэх (үүний үр дүнд бий болсон их биеийн хохирол, хариуцлагын асуудлын даатгалаар хамгаална)

Нэмэлтээр авч болох хамгаалалтад:

- гэнэтийн ослын даатгал
- эмчилгээний зардлын хамгаалалт
- хувийн эд зүйлсийн хамгаалалт
- зөвхөн даатгуулагч нь өөр тээврийн хэрэгсэл жолоодож байх үед хариуцлагын хамгаалалт нь үйлчлэх нөхцөлтэй байх

Хувийн тээврийн хэрэгслийн даатгал:

Нэмэлтээр авч болох бусад хамгаалалтууд:

- шилний хохирол (иж бүрэн хамгаалалтаас бусад нөхцөлд)
- хувийн эд зүйлс, хувцас
- түрээсийн автомашины үйлчилгээ авах
- гэнэтийн ослын даатгал
- чиргүүл, трэйлэр
- автомашин гэнэт эвдрэх асахгүй болох /breakdown/
- хуулийн үйлчилгээний зардлын хамгаалалт гэх мэт.

Хувийн мотоциклийн даатгал:

- жижиг эд ангийн хулгайд хамгаалалт байхгүй
- хувийн эд зүйлс, гэнэтийн осол, эмнэлэг эмчилгээний зардлын хамгаалалт өгдөггүй. Гэнэтийн ослын хамгаалалтыг нарийн хязгаарлалттай нөхцөлд нэмэлтээр зарим тохиолдолд олгодог.



Байгууллагын тээврийн хэрэгслийн даатгал /Fleet insurance/:

1. Түгээлтийн автомашин /жижиг, том бүгд/
2. ХАА-н зориулалттай /жишээ нь трактор гэх мэт/
3. Зорчигч тээвэрлэх зориулттай /түрээсийн, жижиг автобус, хот хоорондын автобус гэх мэт/
4. Тусгай зориулалтын автомашин /түргэн тусламж, кран, өргөгч, хүнд даацын гэх мэт/

Байгууллагын тээврийн хэрэгслийн даатгал нь хувийн тээврийн хэрэгслийн даатгалтай ихэнх талаараа төстэй боловч дараах зүйлсийг авч үзэх шаардлагатай болдог:

- ачаа бараа зөөдөг бол тухайн ачаа барааг даатгалд оруулахгүй байх, хэрэв жижиг дунд бизнесийн эрхлэгчийн овор хэмжээ бага, цөөн тооны бараа зөөн тээвэрлэдэг тохиолдолд түүнийг нь хамгаалалтанд оруулах
- гэнэтийн ослын даатгал, хувийн эд зүйлсийн хамгаалалтыг олгохгүй байх
- тээврийн хэрэгслийг хаана зогсоолд байршуулдаг, юу зөөж тээвэрлэдэг, өөрийн бараа юу хүний бараа юу, онцгой нөхцөл шаарддаг эсвэл аюултай бараа бүтээгдэхүүн үү гэх зэргээс хамаарч хураамжийн хэмжээ өөр байна.
- **гуравдагч этгээдийн хүлээх хариуцлагын хэмжээ:** Андеррайтер тухайн тээврийн хэрэгслийг юунд ашигладаг, зөөж байгаа бараа зэргээс хамаарч хязгаар үнэлгээг тогтоож өгдөг.



Байгууллагын тээврийн хэрэгслийн даатгал /Fleet insurance/:

- **Бараа буулгах, ачих:** энэ тохиолдолд хамгаалалт үйлчилнэ. жишээ нь бараа буулгах үед ойр орчимд байгаа бусад тээврийн хэрэгслийг гэмтээх
- **Жолоочийг хамгаалах /indemnity to driver/:** тухайн жолооч нь байгууллага буюу даатгуулагчийн олгосон эрх, зааврын дагуу тухайн тээврийн хэрэгслийг жолооддог. Ослын тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг жолоодож байсан жолоочийн эсрэг хуулийн маргаан үүсэх боломжтой тул жолооч, байгууллага аль алийг нь хамгаалах тухай авч үзэх чухал буюу аливаа хамгаалалтын хийдэл, зөрүү үүсгэхгүй байх тухай бодох хэрэгтэй.
- **Хэрэглэгчийн хамгаалах /indemnity to user/:** Даатгуулагч өөрийн тээврийн хэрэгслийг өөр бусдад хэрэглүүлэх тохиолдлууд байдаг. Энэ үед тээврийн хэрэгслийг тухайн жолооч нь гэрийн хэрэгцээнд унах, ажил олгогчийн заавраар өөр жолооч жолоодох гэх мэт тохиолдол бий болно. Иймд жолоодох, ашиглах хоёр нь хоорондоо ялгаатай тул үүнийг андеррайтер авч үзэн даатгалын хамгаалалт үйлчилдэг байхаар бодох шаардлагатай болдог.
- **Зорчигчийг хамгаалах /indemnity to passengers/:** Зорчигчийн буруутай үйлдлийг хариуцлагад даатгал үйлчилдэг байх. Жишээ нь зорчигч санамсаргүйгээр хаалгаа онгойлгох үед хажуугаар нь дугуйтай хүн явж тааран түүнийг хаалгаараа цохиж гэмтээх асуудал үүсвэл энэ тохиолдолд жолооч эсвэл зорчигчийн эсрэг нэхэмжлэл үүсэх тул үүнийг даатгалаар нөхөн төлдөг байхаар бодож үзэх нь чухал юм.
- **Хуулийн зардлуудын хамгаалалт**



Байгууллагын тээврийн хэрэгслийн даатгал /Fleet insurance/:

Зарим сонголттой нэмэлт хамгаалалтууд байдаг /зарим тохиолдолд үндсэн хамгаалалтдаа багтаж болно/:

- Эмчилгээний зардал
- Салхины шилний хамгаалалт – хүнд даацын, том хэмжээний ачааны автомашины салхины шилний хэмжээ, салхины шил хагарах давтамж, цар хүрээг авч үзэх шаардлагатай
- Loss of use
- Овор ихтэй, ачааны, газар ухдаг, хүнд даацын автомашин, кран зэргийн хэмжээ, хийж буй ажлын цар хүрээнээс хамаарч бусдад учруулах гэмтэл, хохирлын хэмжээ нь өндөр тул тэдгээрийн хариуцлагын үнэлгээ хязгаарыг нэмэгдүүлдэг.
- Түрээсийн тээврийн хэрэгсэл /indemnity to hirers/ - Өөрийн тээврийн хэрэгслээ байнгын давтамжтайгаар түрээсэнд гаргадаг байгууллагуудад зориулж аливаа ослын үед тухайн тээврийн хэрэгслийг түрээсэлж байгаа хувь хү, байгууллагад хамгаалалт үйлчлэх

Fleet insurance буюу байгууллагын тээврийн хэрэгслийг багцалж даатгах нь:

- ✓ Даатгагч багцаар даатгах хамгийн багадаа байх тээврийн хэрэгслийн тоог зааж өгдөг. Ихэвчлэн 10 ширхэг гэх мэт
- ✓ Ингэснээр гэрээн дээр ажиллах үйл ажиллагааны зардлыг бууруулах ба тээврийн хэрэгсэл бүрийн өөрчлөлтийг тухай бүрт хийлгүй тохирсон хугацаагаар хураамжид өөрчлөлтийг бүртгэх гэх зэрэг орно.



Тээврийн хэрэгслийн даатгалд андеррайтингийн авч үзэх зүйлс:

- Жолоочийн нас – 17-25 насны жолооч нар туршлага багатай, эрсдэлийг авч үздэггүй байдал нь илүү байх, харин 40-50 насны жолооч нар илүү туршлагатай, хашир байдаг гэх мэт.
- Тээврийн хэрэгслийн төрөл, үйлдвэр – Үнэтэй, ховор, содон автомашин нь илүү үнэлгээ өндөр, засахад төвөгтэй байдаг, өндөр хүчтэй автомашин удирдахад хэцүү байдаг гэх мэт. Харин байгууллагын хэрэгцээний тээврийн хэрэгслүүдэд өндөр хураамж тогтоох магадлалтай байдаг. Учир нь төрөл бүрийн автомашин байх ба хэрэглээ зориулалт хэмжээ нь янз бүр, хариуцлагын хамгаалалт өндөр байх шаардлагатай байдаг.
- Ашиглах зориулалт
- Газар зүйн байршил
- Хаана зогсоодог байршил
- Жолоочийн жолооны түүх
- Нэмэлтээр авахыг хүссэн хамгаалалтууд
- Тээврийн хэрэгслийг засч өөрчилсөн байдал – үнэтэй нэмэлт эд анги тавих, уралдааны зориулалтаар нэмж өөрчлөх зэрэг нь хулгайн эрсдэлийг нэмэгдүүлдэг.



Эрүүл мэндийн даатгал:

- **Гэнэтийн ослын даатгал** – гэнэтийн ослын улмаас нас барах, бэртэх гэмтэх үед мөнгөн дүнгээр тэтгэмж олгох
- **Өвчтэй байх үеийн даатгал** – өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй байх хугацаанд тэтгэмж олгох
- **Эмчилгээний зардлын даатгал** – өвчтэй үед эмнэлэг эмчилгээний заардлыг төлөх

Гэнэтийн осол, өвчтэй байх үеийн даатгал нь олгох мөнгөн дүнгээ урьдчилан тохирч даатгуулах ба тохирсон нөхцөл болзол бүрдсэн үед шууд санхүүгийн хохирол үүссэн эсэхээс үл хамааран тохирсон мөнгөн дүнгээр тэтгэмж авах даатгал юм. /Benefit policy/

Даатгалын үйлчлэх, хамаарах хугацаа нь даатгуулагчийн ажлын цаг эсвэл 24 цагаар гэж заадаг.

Гэнэтийн осол, өвчтэй байх үеийн даатгалыг хувь хүн өөртөө авч болно, эсвэл байгууллага өөрийн ажилтнуудаа даатгуулж болдог.

Хамрагдах насны хувьд 16 - 65 нас хүртэл байх ба гэнэтийн ослын даатгалын хувьд 16 – 70 нас хүртэл, өвчлөлийн хамгаалалтын хувьд 16 – 60 нас хүртэл гэж зааж болдог.

Байгууллага өөртөө уг хамгаалалтуудыг авсан тохиолдолд дараах хамгаалалтууд ордог:

- түр хугацаанд орлож ажиллах ажилтны зардал
- өвчтэй, гэмтсэн ажилтанд үргэлжлүүлэн олгох цалингийн зардал /заавал хууль ёсны олгодог цалингийн хэмжээнээс давсан байх/
- удирдах эсвэл key ажилтны эмчилгээний зардал
- нас барсан тохиолдолд тохирсон тэтгэмж, оршуулгын зардлыг ар гэрт нь олгох

Гэнэтийн ослын даатгал:

Бүтэн дүнгээр тэтгэмж олгох нөхцөл (capital benefit):

- Нас барах
- Эрхтэн, хараа, хэл яриа, сонгсголоо алдах – Даатгуулагч үүнийгээ нотлох үүрэгтэй ба даатгагч нь тохирсон хугацаанд буюу анхны бэртэл гэмтлээс хойш 52-104 долоо хоног дотор уг бие махбодийн хохирол үүссэн байх шаардлага тавьдаг. Уг хохирол үүсэх хүртэл хугацаанд долоо хоногийн тэтгэмж олгох ба хохирол үүссэн гэдгийг баталгаажуулсан үед бүтэн дүнгээр тэтгэмж нэмж олгоно.
- Хөдөлмөрийн чадвар бүрэн алдах – Ослоос хойш 52-104 долоо хоног дотор хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан нь тогтоолгох ба дахин сэргэх боломжгүй тархины гэмтэл, саажилт гэх мэт нөхцөлийг хэлнэ.
- Хэсэгчилсэн байдлаар хөдөлмөрийн чадвар бүрэн алдах – Даатгагч анх тохиролцсон хувиар тооцон тэтгэмж олгох нөхцөл. Жишээ нь: нэг хуруугаа алдахад нийт үнэлгээний 20%-р тэтгэмж олгох гэх мэт.
- Түр хугацаагаар хөдөлмөрийн чадвар бүрэн алдах – Анх тохиролцсон нөхцөлийн дагуу 52-104 долоо хоног хүртэл хугацаанд долоо хоног бүр тэтгэмж олгох ба даатгагч энэ тохиолдолд 7,14,21 гэх мэт franchise босго хугацааг тогтоож өгдөг.
- Гэмтэл, бэртлээс үүдэн даатгуулагч өөрийн ажил үүргийн тодорхой нэг хэсгийг цаашид гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд үүнийг түр хугацааны хөдөлмөрийн чадвар алдалт гэж үзэн даатгагч долоо хоног бүр олгох тэтгэмжийн дүнг 30%,40% хүртэл гэх мэтээр бууруулан тэтгэмж олгодог. Бууруулж буй шалтгаан нь даатгуулагч өөрийн ажил үүргийн зарим хэсгийг гүйцэтгэж чадаж байгаа гэж үзнэ.



Өвчтэй байх үеийн хамгаалалт:

Уг хамгаалалт нь гэнэтийн ослын даатгалд нэмэлт хамгаалалт хэлбэрээр санал болгодог ба даатгуулагч өвдсөн үедээ ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон түр хугацаагаар хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гэж үзэн 7 хоногийн давтамжтай тэтгэмж олгох нөхцөлтэй байдаг. Franchise босго хугацааг заавал оруулна.

Нэмэлтээр санал болгодог хамгаалалтууд:

- Даатгуулагч алга болох – хэрвээ даатгуулагч сураггүй алга болсон бол 6 сарын хугацаанд хүлээх ба 6 сар өнгөрвөл түүнийг нас барсан гэж үзэн бүтэн дүнгээр тэтгэмж олгоно.
- Даатгуулагчийн эдгэрэх хугацааг түргэсгэх эмчилгээний зардлууд
- Гэр бүлийн гишүүн нь асрах тохиолдолд эмчилгээний нийт хугацаанд нэг хоногийн тодорхой дүнгээр төлөх

Стандарт хасалт нөхцөлүүд:

- Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн
- Өөрийгөө гэмтээсэн
- Төрөх, жирэмслэлт, ДОХ, арьс өнгөний өвчин
- даатгалаас өмнөх үеийн гэмтэл бэртэл өвчин
- Мотоцикл унаж байх үед, хөлөөрөө гүйхээс бусдаар уралдаан тэмцээнд орох, өвлийн спорт, ууланд авирах спорт гэх мэт



Орон байрны даатгал /household insurance/:

- A. Байшин барилгын даатгал /buildings insurance/
- B. Доторх тавилга эд зүйлсийн даатгал /contents insurance/ - ихэвчлэн хөрөнгийн нийт үнэлгээний 5% орчимд үнэлгээг тооцдог.
- C. Нэмэлт хамгаалалтууд /optional extensions/ :
 - Бүх эрсдэл нөхцөлтэй байх
 - Бэлэн мөнгө, кредит карт
 - Унадаг дугуй, Чиргүүл
 - Жижиг механизм хэрэгсэл – цагт 32 км цагаас хэтрэхгүй хурдтай байх
 - Гэнэтийн осол, эмчилгээний төлбөр, зээлдэгчийн төлбөрийн хамгаалалт
 - Тэжээвэр амьтны хамгаалалт
 - Хуулийн үйлчилгээний зардлын хамгаалалт

A. Байшин барилгын даатгал /buildings insurance/

- Гал, аянга цахилгаан, дэлбэрэлт, газар хөдлөлт
- Бослого, үймээн самуун, иргэний хөдөлгөөн, улс төрийн жагсаал цуглаан, санаатай хорлон сүйтгэлт
- Хүчтэй салхин шуурга, үер
- Мод, мөчир унах
- Усанд автах – ус түрж орж ирэх эсвэл шугам хоолой, халаалт, өөр бусад төхөөрөмжөөс ус алдах
- Хулгай, хулгайлахаар оролдох
- Бусад зүйлсын нөлөөлөл – онгоц, агаарт байх бусад төхөөрөмж дээрээс унах, тээврийн хэрэгсэл, мал амьтан дайрах мөргөх.
- Хөрсний суулт, газрын хагарал, хөрсний гулсалт нуралт - өөрийн хариуцах хэсэг өндөр байдаг
- Ус зайлуулах хоолой, шугам хоолой, кабель, газар доогуурх шугам хоолойд гэнэтийн гэмтэл гарах
- Цонх шил хагарах, ариун цэврийн өрөөний хэрэгсэл хагарах
- Хуулийн үйлчилгээний төлбөр, үнэлгээчин, архитекторийн ажлын хөлс, хог хаягдал зайлуулах зардал

Орон байрны даатгалд андеррайтингийн авч үзэх зүйлс:

- Барилгын хийц – Даатгагчийн гол анхаарах зүйл нь юугаар барьсан бэ гэдэг юм.
- Байршил – Даатгагчид шуурга, үер, хөрсний суулт, гэмт хэрэг, дээрэм гэх мэт эрсдэлийг байршлуудад ямар хэмжээтэй байгааг үнэлж дүгнэх системд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтууд хийдэг.
- Өдрийн цагаар хэрхэн харж ханддаг байдал
- Хамгаалалтын систем



Байгууллагын Хөрөнгийн Даатгал

- Гал ба тусгайлсан эрсдэлийн даатгал
- Бүх эрсдэл нөхцөлтэй даатгал
- Хулгайн даатгал
- Шилний хохирлын даатгал
- Бэлэн мөнгөний даатгал



Гал ба тусгайлсан эрсдэлийн даатгал

- Гал (галаас үүдэлтэй дэлбэрэлт, газар хөдлөлт, газрын гүнээс үүдэлтэй гал, хэт халалт, аажмаар халсаар гарсан гал зэрэг орохгүй)
- Аянга цахилгаан
- Дэлбэрэлт – санамсаргүйгээр газ алдаж тархах, химийн урвалаас гарах дэлбэрэлт хамаарна. Харин хэрэглээндээ ашиглаж буй бойлер, уурын даралтат бусад тоног төхөөрөмжийн дэлбэрэлт үүнд орохгүй.
- Онгоц, түүний хэсэг эд анги дээрээс унах
- Бослого, иргэний хөдөлгөөн, үймээн
- Хорлон сүйтгэх үйлдэл
- Газар хөдлөлт
- Аажмаар үүсэх халалт, исэлт, гал
- Салхин шуурга, үер
- Усанд автах – шугам хоолой задраснаас үүдсэн
- Өөрийн болон бусад тээврийн хэрэгсэл мөргөх, дайрах
- Галын бороожуулагчаас ус алдах
- Хөрсний суулт, газрын хагарал, хөрсний гулсалт нуралт

Бүх эрсдэл нөхцөлтэй даатгал

All risks буюу бүх эрсдэл нөхцөлтэй даатгал нь хасалт хэсэгт заасан нөхцөлөөс бусад үед даатгал үйлчлэх нөхцөлтэй даатгалын гэрээ юм. Үндсэн суурь нь гал ба тусгайлсан эрсдэлийн даатгалын нөхцөл дээр суурилах ба гэнэтийн шинж чанартай хохирлуудад илүү өргөн хүрээнд хамгаалах боломжийг олгосон гэрээ юм. Мөн хасалт хэсэгт тусгайлсан нэмэлт нөхцөлүүд оруулдаг.

Хасалт хэсгийг үндсэн 4 хэсэгт хувааж үзнэ:

- **Зайлшгүй байх хасалт нөхцөл /absolute exclusion/:** дайн, бохирдол, халдвар, үр дагаврын хохирол
- **Аажмаар бий болох нөхцөлийн хасалтууд /gradually operating exclusions/:** зэвд идэгдэх, хөрөнгийн хаалга дээвэр нээлттэй үед салхи бороо орох гэх мэт
- **Гэрээнд тусгайлан бичигдсэн нөхцөлүүд:** бэлэн мөнгө, шил, хөрсний суулт гэх мэт
- **Өөр төрлийн даатгалд хамрагдах хөрөнгө, эрсдэл:** тээврийн хэрэгсэл, онгоц гэх мэт

Гал ба тусгайлсан эрсдэлийн хөрөнгийн даатгалын андеррайтингийн авч үзэх зүйлс:

- **Зориулалт:** авто зогсоол, оффис, юуны үйлдвэр вэ гэх мэт
- **Ямар төрлийн бараа дотор нь агуулж байгаа:** цаас, хувцас, шатамхай бодис гэх мэт
- **Барилгын бүтэц, материал:** сүүлийн жилүүдэд полистирол бетон блок, хавтанг дулаалгын материалд илүү ашиглах болсон нь хураамжийг илүү нэмэгдүүлж байна. Мөн сэндвич панель илүү ашиглах болсон нь өндөр эрсдэлтэй гэж үзэж багаа.
- **Аюулгүй байдлын арга хэмжээ:** галын систем, галын хаалт, бороожуулах систем гэх мэт
- **Эрсдэлийн удирдлагын бодлого:** өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, туслан гүйцэтгэгч нарыг хэрхэн ажлуулж байгаа байдал, аудит, судалгаа шинжилгээ хийгддэг байдал, давтамж, засвар үйлчилгээ хийгддэг байдал
- **Барилгын давхар, хэмжээ**
- **Халаалт, гэрэлтүүлгээ хэрхэн шийдсэн байдал**
- **Барилгын байршил дээрх үүсч, нөлөөлж болох эрсдэлүүд:** салхи шуурга, үер, хөрсний суулт, хулгай дээрэм гэх мэт

Бүх эрсдэл нөхцөлтэй гэрээний хувьд дээрхтэй ижил зүйлсийг авч үзэх боловч хамгаалалтын хүрээ илүү өргөн байдаг тул хураамж тооцоолол, нөхцөл дээр илүү нарийн бодож тооцооллох хэрэгтэй бодог.

Хулгайн эрсдэлийн даатгал

Хулгайн эрсдэлийн даатгалд зөвхөн “хүч хэрэглэн, нөлөө үзүүлж” үйлдсэн хулгайг тооцно.

Нийтлэг нэмэлт хамгаалалтуудад:

- шил хагалах
- түлхүүрээ гэсэн тохиолдолд түлхүүр цоожийг шинээр солих зардал. Учир нь даатгагч гэсэн түлхүүр, эвдэрхий цоож зэргээс болж их хэмжээний хулгай гарахаас сэргийлэн урьдчилан бага хэмжээний зардлыг төлөхийг илүүд үздэг.
- хэсэг хугацаанд нүүлгэн шилжүүлсэн үеийг даатгах – агуулах байрыг засах, цэвэрлэх, өөрчлөх зэрэг үед өөр тийш нүүлгэсэн үед хамгаалалт үйлчилнэ
- **Index-linking** буюу даатгалын хугацааны турш инфляцийн нөлөөг авч үзэх ба даатгалын гэрээний төгсгөлд хураамжийн өөрчлөлтийг хийдэг. Даатгалын хугацааны дундуур бараа материалын үнэ өссөн үед нөхөн төлбөр олгох бол дутуу даатгуулсан гэж үзэн дундаж тооцох нөхцөл үүсэхээс сэргийлсэн хамгаалалт юм.
- “Хүч хэрэглэн, нөлөө үзүүлж” орох гэх нөхцөл үйлчлэхгүй болгох хамгаалалт. Энэ нь ихэвчлэн үйлдвэр, бараа материалын агуулах шөнийн турш нээлттэй ажиллагаатай байдаг тохиолдолд авч үздэг.

Ерөнхий хасалт нөхцөлүүд:

- Ажилтантай хуйвалдан хулгай үйлдэх – энэ тохиолдлыг андеррайтер нэмэлт хураамжтайгаар даатгалын хамгаалалтад оруулж болдог.
- Гал, дэлбэрэлт
- Бэлэн мөнгө, чек, үнэт цаас гэх мэт
- Мал амьтан

Хулгайн эрсдэлийн даатгалд андеррайтингийн авч үзэх зүйлс:

- Жижиг хэмжээний эрсдэлийг даатгах үед андеррайтер дохиоллын ситем, аюулгүй байдлын системийн стандартыг хангах тухай урьдач нөхцөл буюу warranty тавьдаг.
- Андеррайтер тухайн барилгад байгаа бараа материал, эд зүйлсийг ангилж үзэн хулгайч ямар төрлийн бараа эд зүйлсийг “онилж” хулгайлах вэ гэдгийг тооцон ердийн ширээ сандал, оффисийн жижиг эд зүйлс гэх мэт энгийн хэрэглээний зүйлс дээр хураамжийг багасган тооцох, харин үнэт эдлэл, компьютер тоног төхөөрөмж, архи дарс гэх мэт сонгон онилж хулгайлах зүйлс дээр хураамжаа өөрөөр тооцдог.
- Хулгайн эрсдэлийн даатгалын хураамжийг тооцохдоо нийт тооцож буй хамгийн их хохирлын хэмжээнээс /estimated maximum loss/ тооцдог ба үүнийгээ даатгалын нийт үнэлгээ гэж тооцно. Гэхдээ даатгуулагчийн зүгээс бүх бараа материалаа хулгайд алдах эрсдэл байхгүй гэж үзэн хураамжаа бууруулах хүсэлт тавих бол First Loss Policy нөхцөлөөр даатгалын үнэлгээг тооцон гэрээг хийх боломжтой.
- Даатгуулагчийн худалдаа үйлчилгээний чиглэл
- Газарзүйн байршил
- Даатгуулагчийн зан төлвийн байдал /moral hazard/
- Барилгын хийц, үндсэн шинж чанар
- Хулгайгаас сэргийлэхээр авсан арга хэмжээ

Шилний даатгал

Гал ба тусгайлсан эрсдэлийн даатгал, хулгайн даатгал, бүх эрсдэл нөхцөлт гэрээнд гэрээний үндсэн эрсдэлээс үүдэн шилэнд хохирол учирсан тохиолдолд даатгал үйлчлэх боловч гэнэтийн хохиролд шилний хохирлыг хасалт хэсэгт оруулсан байдаг. Иймд их хэмжээний шил агуулсан барилгууд тусдаа даатгал авах шаардлага үүсдэг.

Стандарт даатгалын гэрээ нь бүх төрлийн суурьлуулсан шил, цонх, хаалга, тааз, хана, толин шил орно. Мөн хагарсан шилийг шинээр солих хүртэл түр хугацаанд хаах зорилгоор хийсэн хамгаалалт шилний зардлыг мөн тооцдог.

Шил жижиг цуурсан, зурагдсан зэргийг нэмэлт хураамжтайгаар даатгаж болно.

Гал, аянга цахилгаан, дэлбэрэлтээс үүдсэн хохирол хасалт хэсэгт орно учир нь тусдаа даатгалын бүтээгдэхүүн байгаа тул түүгээр даатгуулах ёстой.

- Андеррайтерийн гол анхаарах зүйл нь тухайн барилгын зориулалт, газарзүйн байршил юм. Барилгын зориулалт ашиглалт нь шилний хагарах нөхцөлтэй хамааралтай байдаг ба барилгын байршил нь хаана байхаас хамааран хорлон сүйтгэх үйлдэл гарах нөхцөлийг харна.



Бизнес Тасалдлын Даатгал

Бизнес тасалдлын даатгал нь хөрөнгийн даатгалаар хөрөнгөд хохирол учирсанаас үүдэн бодит эсвэл олох ёстой байсан ашиг буурах, нэмэлт гарах зардлыг төлөх зорилготой. Хөрөнгийн хохирол учирсанаас гадна:

- ашиг буурах эсвэл түр зогсох
- тодорхой ажилтнуудад бүтэн цалинг олгох шаардлага үүсэх
- бизнесийн үйл ажиллагаагаа цааш үргэлжлүүлэхийн тулд зарим зардал нэмэгдэх асуудал үүсдэг.

Дээрх зүйлс дээр нэмэлтээр хохирлыг тооцоход ажиллах нягтлан бодох мэргэжилтний ажлын хөлсийг нэмж тооцон нөхөн төлбөр олгодог.

Бизнес тасалдлын даатгалын хэрэгцээ шаардлагыг үнэлэхийн тулд тухайн бизнес нь биет хохирлоос үүдэн хэдий хугацаанд тасалдаж болохыг урьдчилан тооцдог ба уг хугацааг нөхөн төлбөр тооцох хугацаа /indemnity period/ гэж нэрлэдэг. Даатгуулагч өөрөө уг хугацааг сонгодог ба дунджаар 6-36 сар хүртэл хугацаа байдаг.

A maximum indemnity period may exceed the policy period, as below:



Бизнес Тасалдлын Даатгал

Даатгалын үнэлгээг тооцохдоо:

Нөхөн төлбөр тооцох хугацаа хугацаанд тооцогдох нийт ашгийн /gross profit/ хэмжээгээр тооцож авна.

Gross profit = (Turnover + Closing stock) + (Opening stock + Uninsured working expenses)

Turnover – Нийт орлого

Closing stock – түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бараа бүтээгдэхүүн

Opening stock – нягтлан бодох бүртгэлийн хугацаа эхлэхэд борлуулагдахаар хүлээгдэж буй бэлэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний бүртгэл дээрх үнэ

Uninsured working expenses – those costs which vary in direct proportion to the level of turnover such as raw materials, electricity etc.

Цалингийн зардлийг хамгийн бага хэмжээнд гэж тооцон бүтэн хэмжээгээр даатгалын үнэлгээнд оруулдаг.



Бизнес Тасалдлын Даатгал


Бизнес тасалдлын даатгалын гэрээгээр даатгах гол зүйлс:

- **нийт ашгийн бууралт /loss of gross profit/**
- **нэмэлт ажиллах хүчний зардал /increased cost of working ICOW/**

Бизнес тасалдлын хамгаалалт үйлчлэх урьдач нөхцөл нь материалын хохирол учирсан байх нөхцөл буюу хөрөнгийн даатгалтай байх нөхцөл тавьдаг.



Нийт ашгийн бууралт тооцох



Нийт ашгийн түвшин /gross profit rate/ %: $\frac{\text{Жилийн эргэлт /annual turnover/} - \text{ББӨ /cost of goods sold/}}{\text{Жилийн эргэлт /annual turnover/}}$

Нийт ашгийн бууралт: Gross profit rate x (Standard turnover - Reduced turnover)

Нэмэлт ажиллах хүчний зардал /increased cost of working ICOW/

If fire were to destroy an accountancy firm's office, the firm would lose its furniture, computer systems, records, stationery and other items. The insurer would appoint a loss adjuster whose function is to settle the claim on the insurer's behalf as quickly and economically as possible. So how would the loss adjuster tackle the task? First, the company would need alternative accommodation which the loss adjuster would try to find. If there are suitable premises in the area this could take a few days. Provided the accountancy firm owns its building or is responsible for insuring it, the property insurance would reinstate the building (i.e. restore it to the state it was in before the fire), although this could take up to a year to complete. Second, the loss adjuster would hire computers and office equipment for the temporary office. The insured might decide to tell customers about the move by advertising or holding an event at its new premises. The firm could be up and running again very quickly and would not have incurred a substantial loss of profits. The ICOW cover would provide for the costs of hiring alternative premises, office equipment and informing clients of the move.

A second scenario might involve a haulage contractor. A fire at its warehouse would destroy stock and any offices. However, the lorries, which earn the profits, would probably be out on the road or in the yard. The loss adjuster would simply need to hire a 'portacabin' office and find a temporary warehouse to hold stock pending the rebuild. The profits would not be unduly affected and ICOW would be an appropriate form of interruption cover.



Бизнес Тасалдлын Даатгал

Нэмэлт хамгаалалтууд:

- **Ханган нийлүүлэгчийн тасалдал:** Хэрвээ ханган нийлүүлэгч нь даатгуулагчийн түүхий эд материалыг хугацаанд нь нийлүүлж чадахгүй үед даатгуулагч эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжгүйгээр их хэмжээний хохирол учрах боломжтой. Даатгуулагч өөр боломжит ханган нийлүүлэгчгүй үед энэ нь том эрсдэл болох юм. Даатгагчийн зүгээс уг нөхцөлийг даатгах тохиолдолд ханган нийлүүлэгчийн барилгад эрсдэлийн үнэлгээ хийлгэх хүсэлт тавьдаг. Энэ тохиолдолд даатгалын үнэлгээний 10% гэсэн дэд хязгаарлалт тавих ба ханган нийлүүлэгчийн барилгад хохирол учирсан нь даатгуулагчийн ашигт сөргөөр нөлөөлсөн тохиолдлыг авч үзнэ.
- **Тусгай нэрлэсэн худалдан авагч:** Дээрх нөхцөлтэй ижил боловч даатгуулагчийн худалдан авагчийн барилгад хохирол учирснаас даатгуулагчийн бараа материалыг худалдан авахаас татгалзах нөхцөл юм.
- **Ачаа тээвэр**
- **Барилгад нэвтрэх боломжгүй болох**
- **Нийтийн шугам хоолойд гэмтэл гарах**
- **Барилгад ноцтой халдварт өвчин гарах, хүн амины хэрэг гарах, амиа хорлох**
- **Даатгуулагчийн ажиллаж байсан ажлын талбайд хохирол учрах**



Бизнес Тасалдлын Даатгалын андеррайтингийн авч үзэх зүйлс:

Даатгагчийн гол анхаарал хандуулах зүйл нь даатгуулагч хэр хурдан хугацаанд бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн болгох вэ гэдэгт байна.

- Даатгуулагч өөр байршлаас үйл ажиллагаа явуулах боломжтой юу?
- Орлуулах тоног төхөөрөмж нь бэлэн байгаа юу?
- Гол чухал тоног төхөрөөмжийн эд ангийн нөөц бэлэн байгаа юу? Үйлдвэрлэх хэсэг, ажлын талбай зэрэг нь хоорондоо хэр холбоо хамааралтай байдаг вэ?
- Улирлын шинж чанартай нөлөөлөл байгаа юу?
- Ханган нийлүүлэгч, худалдан авагч, засвар үйлчилгээ үзүүлэгч зэргийн хамааралтай байдлыг судлах



Хариуцлагын даатгалууд

- Ажил олгогчийн хариуцлагын даатгал
- Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын даатгал
- Бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлагын даатгал
- Бохирдуулсанаас үүсэх хариуцлагын даатгал
- Мэргэжлийн хариуцлагын даатгал
- Удирдах ажилтны хариуцлагын даатгал

Ерөнхий хариуцлагын даатгал
/Commercial General Liability

Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын даатгал

- Гэнэтийн осол: даатгуулагчийн санаатай үйлдэл, хэт хайхрамжгүй байдал орохгүй
- Бие махбодийн гэмтэл бэртэл: бие махбодид гэмтэл учирсан байх, эрүүл мэндийн хувьд доройтсон байх
- Хөрөнгөд хохирол учрах: шууд бус эдийн засгийн хохирол, биет бус хөрөнгийн хохирол орохгүй
- Үр дагаврын хохирол: жишээ нь тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан тохиолдолд засварт байх хугацаанд өөр тээврийн хэрэгсэл түрээслэх зардлыг төлнө
- Хариуцлагын хязгаар: нэг удаагийн тохиолдолд олгох дэд хязгаарыг тогтоодог.

Хасалт хэсгүүд:

- Бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлага
- Гэрээний хариуцлага
- Алдаатай гүйцэтгэсэн ажлыг дахин засах зардал /cost of rectifying of defective work/: муу ур чадвараар /poor workmanship/ гүйцэтгэсэн ажлыг дахин засах сайжруулахаар гаргаж буй зардлыг төлөхгүй. Харин тухайн муу гүйцэтгэсэн ажлаас үүдэн гуравдагч этгээдэд учирсан хохирлыг төлдөг.
- Мэргэжлийн алдаа
- Тээврийн хэрэгслийн хариуцлага
- Лифт, цахилгаан шат, бойлороос үүдэх хариуцлага
- Дайн, цацраг идвэхийн хариуцлага

Бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлагын даатгал

Уг даатгал нь даатгуулагчийн үйлдвэрлэсэн, угсарсан, өөрчилсөн, зассан, үйлчилгээ үзүүлсэн, борлуулсан, нийлүүлсэн, дистрибьютор борлуулсан бараа бүтээгдэхүүнээс үүдэн бие махбодь, эрүүл мэнд, хөрөнгөд хохирол учирч хуулийн хариуцлага хүлээх үед үйлчилнэ. Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын хамт борлуулдаг ба дангаар нь борлуулдаггүй.

Даатгалын хамгаалалт нь:

- Бодит учирсан гэмтэл бэртэл хохирлоос үүдсэн үр дагаврын хохиролд даатгал үйлчилнэ

Даатгал үйлчлэхгүй нөхцөл:

- Гэрээний хариуцлага
- Нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн өөрт нь учирсан хохирол. Даатгагч нь гэмтэлтэй барааг оруулах шинээр солих зардлыг төлөхгүй ба энэ нь үйлдвэрлэгчийн асуудал юм.
- Faulty design and formula. Даатгагч нь үүнд нөхөн төлбөр төлөхгүй ба уг бүтээгдэхүүнээс үүдэн өөр бэртэл гэмтэл хөрөнгийн хохирол учраагүй л бол нэхэмжлэлийг авахгүй.

Бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлагын даатгалд андеррайтерийн гол авч үзэх зүйл нь даатгуулагчийн худалдаа, үйлчилгээ, бизнесийн чиглэл юм. Эрсдэлийн үнэлгээ хийх явцдаа андеррайтер нь эцсийн бүтээгдэхүүний хэрэглээ, түүний бие махбодь эд хөрөнгөд хохирол учруулах боломжит шалтгааныг олохыг хичээх юм.



Мэргэжлийн хариуцлагын даатгал

Мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлдэг хүн өөрийн мэргэжлийн үүргээ зөрчсөн, хайхрамжгүй үйлдэл хийсэн, мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлж байхдаа алдаа дутагдал гаргасан зэргээс үүдэн харилцагч үйлчлүүлэгчдээ санхүүгийн хохирол, гэмтэл бэртэл учруулсанаас үүсэх хариуцлагын асуудлыг даатгах даатгал нь мэргэжлийн хариуцлагын даатгал юм. Ихэнх нэхэмжлэл нь санхүүгийн хохиролтой холбоотой байдаг.

Мэргэжлийн ажил үйлчилгээндээ хайхрамжгүй хандсан үйлдлээс улбаатай хохирол нь цэвэр санхүүгийн хохирлууд байдаг ба шүүхээс шийдвэрлэхдээ тухайн тохиолдолд гэмтэл бэртэл учраагүй бол цэвэр санхүүгийн хохиролд нөхөн төлбөр олгох тухай шийдвэр гаргадаг.

Claims made versus losses occurring policy



Under a claims-made policy, the claim attaches to the year it is made, not when the advice was given.



Удирдах ажилтны хариуцлагын даатгал

Компаний тухай хуулинд Эрх бүхий албан тушаалтан дараах үүрэгтэй:

- 84.4.1.хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;
- 84.4.2.үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;
- 84.4.3.компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;
- 84.4.4.шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх;
- 84.4.5.өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;
- 84.4.6.компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

Хүлээх хариуцлага:

Компанийн эрх бүхий албан тушаалтан дор дурдсан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.



Удирдах ажилтны хариуцлагын даатгал

Standard policy cover offered under a D&O policy has two elements:

- cover for directors and officers in their personal capacity when they are unable to claim an indemnity from the company; and
- cover to protect the company in circumstances where it is permitted to indemnify the directors or officers, such as in the repayment of legal defence costs.

Management liability cover:

- Director's and Officer's liability
- Entity Cover
- Employment practices liability
- Cyber and privacy
- Crime
- Court attendance cost
- Loss mitigation
- Reputation and brand protection

Удирдах ажилтны хариуцлагын даатгал

Standard policy cover offered under a D&O policy has two elements:

- cover for directors and officers in their personal capacity when they are unable to claim an indemnity from the company; and
- cover to protect the company in circumstances where it is permitted to indemnify the directors or officers, such as in the repayment of legal defence costs.

Management liability cover:

- Director's and Officer's liability
- Entity Cover
- Employment practices liability
- Cyber and privacy
- Crime
- Court attendance cost
- Loss mitigation
- Reputation and brand protection

Удирдах ажилтны хариуцлагын даатгал

Стандарт удирдах ажилтны хариуцлагын даатгал дараах 2 элементийг агуулсан байдаг:

- компани өөрөө удирдах ажилтны эсрэг нэхэмжлэл гаргасан тохиолдолд удирдах ажилтны өөрийн хөрөнгийг хамгаалал
- компаний эсрэг нэхэмжлэл ирэхэд компаний хөрөнгийг хамгаалах

Management liability cover:

- Director's and Officer's liability
- Entity Cover
- Employment practices liability
- Cyber and privacy
- Crime
- Court attendance cost
- Loss mitigation
- Reputation and brand protection



Цахим аюулгүй байдлын эрсдэлийн даатгал

IT and IT systems холбоотой дараах нөхцөлд даатгал үйлчилнэ:

- цахим байдлаар хадгалж буй бүх дата мэдээлэл алдагдах
- электрон системээр дамжуулан мөнгө хулгайлах
- цахим ситем унах доголдох, аюулгүй байдал алдагдаж доголдох зэргээс үүссэн бизнес тасалдал
- цахим нууц хувийн мэдээллийг авч барьцаалан мөнгө нэхэх
- харилцагчийн нууц хувийн мэдээллийг алдаснаас үүдэн нэр хүнд унах
- хувийн мэдээлэл нууцлалыг хангаж чадаагүйгээс мэдээллээ алдсан тохиолдолд гуравдагч талд нөхөн олговор өгөх
- харилцагчийн мэдээллийг алдсанаас үүдэн шүүхэд дуудагдахад үүсэх өмгөөллийн зардал
- нууцлалыг хангаж чадаагүй тул торгууль тавиулах

